

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-13</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>14-41</i>
<hr/>	
<i>1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд /Засгийн газраас 2022.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<i>14-38</i>
<i>2. Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын сүүлийн 15 жилийн төсвийн бодлого, төсвийн тэнцэлд дүн шинжилгээ хийх, цаашид баримтлах төсвийн бодлогын талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн дүгнэлттэй танилцах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай/</i>	<i>38-41</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 21 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Г.Амартүвшин, Ц.Анандбазар, С.Ганбаатар, Л.Мөнхбаатар,
Ч.Хүрэлбаатар, Б.Чойжилсүрэн;
Эмнэлгийн чөлөөтэй: Д.Өнөрболор.

Нэг.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд /Засгийн газраас 2022.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, мөн яамны Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн дарга Г.Гийхнаран, мөн хэлтсийн мэргэжилтэн Д.Номингэрэл, Т.Энхжаргал, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 2, 3, 4, 5, 7, 14, 44 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ш.Раднаасэд, Х.Булгантуяа, Ц.Даваасүрэн нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд нар хариулж, тайлбар хийв.

Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Тэмүүлэн: 1.Ажлын хэсгээс гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.3.6 дахь заалтын “сурталчлах” гэснийг “сурталчлахтай холбоотойгоор гадаад улсаас бараа, үйлчилгээ авах” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	4
Бүгд:	12

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.7.1 дэх заалтын “орон нутгийн өмчит,” гэснийг “орон нутгийн төсвийн байгууллага, орон нутгийн өмчит болон” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 2

Бүгд: 12

83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийн “баримтжуулж тендер шалгаруулалтын хувийн хэрэгт хадгална.” гэснийг “баримтжуулна.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 1

Бүгд: 12

91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалтын Тайлбар хэсгийн “дуусах” гэснийг “дуусаж санхүүжилтийн эх үүсвэргүй болох” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 3

Бүгд: 12

75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 42 дугаар зүйлийн 42.3.1 дэх заалтын “банкны” гэсний дараа “, эсхүл Монгол Улсын даатгагчийн” гэж нэмэн, үүнтэй уялдуулж 42.3.3 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 3

Бүгд: 12

75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“43.1.Тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу баталгаа гаргасан бол ажлын бэлтгэл хангахад зориулан гүйцэтгэгчид урьдчилгаа төлбөр төлнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 5

Бүгд: 12

58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 48 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 48.4.10 дахь заалт нэмэх:

“48.4.10.энэ хуулийн 13.4-т зааснаар баримтжуулсан гэрэл зураг, дүрс бичлэг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 49 дүгээр зүйлийн 49.4 дэх хэсгийн “энэ хуульд заасан” гэснийг “Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1-д зааснаас гадна” гэж, мөн зүйлийн 49.4.5 дахь заалтын “үйл ажиллагаатай холбоотой асуудлаар захиалагч, оролцогчийг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах,” гэснийг “ашиглалт, худалдан авах ажиллагааны талаар” гэж өөрчлөн, мөн зүйлийн 49.4.1 дэх заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах:

“49.4.1.цахим системийн үйл ажиллагаа, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлаар захиалагч, оролцогчийг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 49 дүгээр зүйлийн 49.4.10 дахь заалтын “судалгаанд үндэслэн” гэснийг хасаж, мөн заалтын “ерөнхий гэрээний аргаар худалдан авах бараа, үйлчилгээний нэгж үнийн дээд хязгаарыг тогтоох, ерөнхий гэрээний аргаар тендер шалгаруулалтыг зохион байгуулах” гэсэн чиг үүргийг 49.4.11 дэх заалт болгон салгаж, үүнтэй уялдуулан мөн заалтын “судалгаа хийж” гэснийг “судалгаа хийх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 49 дүгээр зүйлийн 49.4.11 дэх заалтын дугаарыг “49.4.12” гэж өөрчлөн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“49.4.12.энэ хуульд заасан баталгааг цахим системээр гаргах эрх бүхий этгээдтэй гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 49 дүгээр зүйлийн 49.5 дахь хэсгийн “өөрийн гүйцэтгэх ажлын тодорхой хэсгийг” гэснийг “энэ хуулийн 49.4.5, 49.4.8, 49.4.10-т заасан чиг үүргийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 49 дүгээр зүйлийн 49.8.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“49.8.3.худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас өгсөн чиглэлийн дагуу энэ хуулийн 49.4.10-т заасан судалгаа хийх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 50 дугаар зүйлийн 50.4 дэх хэсгийн “, хөндлөнгийн” гэснийг хасаж, мөн зүйлийн 50.5, 50.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, үүнтэй уялдуулан 50.7, 50.8 дахь хэсгийг хасах:

“50.5.Үнэлгээний хорооны хараат бус гишүүнээр иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллагын төлөөллийг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотоос бусад орон нутагт аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг сонгоно.

50.6.Үнэлгээний хороонд тухайн бараа, ажил, үйлчилгээнд холбогдох салбарт мэргэшсэн хүнийг томилон ажиллуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 50 дугаар зүйлийн 50.15 дахь хэсгийн “урамшуулал олгох, мэргэшсэн ажилтан бэлтгэх” гэснийг “үнэлгээний хорооны гишүүнд урамшуулал олгохтой холбогдсон” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Тэмүүлэн: Дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 56 дугаар зүйлийн 56.10 дахь хэсгийн “байцаагчид гаргана” гэснийг “байцаагчид гаргаж болно” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 57 дугаар зүйлийн 57.4 дэх хэсгийн “гэрээ байгуулах эрх олгохгүй” гэснийг “энэ хуулийн 28.1-д заасан шийдвэр гаргахгүй” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсгийн “2023 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс” гэснийг “2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Тэмүүлэн: Дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд зүйл, хэсэг, заалт хасах, нэмэх саналтай уялдуулан төслийн холбогдох зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх, мөн төслийн үг хэллэг, нэр томъёог жигдлэх засварыг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “өргөтгөх,” гэсний дараа “буулгах,” гэж, 56 дугаар зүйлийн 56.5.3 дахь заалтын “хохирол” гэсний дараа “барагдуулахыг” гэж, 56.11 дэх хэсгийн “байцаагч” гэсний дараа “энэ хуулийн 56.10-т заасан” гэж тус тус нэмэх;

2.Төслийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “хөгжлийн болон хүнд, хөнгөн” гэснийг “хөгжлийн, хүнд болон хөнгөн” гэж, мөн зүйлийн 8.4.3, 8.7.1 дэх заалтын “хотод хамаарахгүй” гэснийг “хотоос бусад харьяалалтай” гэж, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “аргад үндэслэн” гэснийг “аргаар” гэж, 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийн “нууцалж, бусад хэсгийг ил болгохоор” гэснийг “энэ хуулийн 29.2-т зааснаар ил болгохгүйгээр” гэж, 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсгийн “Засгийн газрын баталсан жагсаалтад” гэснийг “энэ хуулийн 45.2-т заасан жагсаалтад” гэж, 49 дүгээр зүйлийн 49.4.9 дэх заалтын “дүгнэлт” гэснийг “дүн

шинжилгээ” гэж, 49.8.1 дэх заалтын “хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж,” гэснийг “хууль тогтоомжийн хэрэгжилтийн” гэж, 56 дугаар зүйлийн 56.7 дахь хэсгийн “зааснаар улсын байцаагчийн гаргасан санал, дүгнэлтийг” гэснийг “заасан дүгнэлт, зөвлөмжийг” гэж, мөн хэсгийн “биелэлтийн талаар” гэснийг “дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар” гэж, 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсгийн “сонирхолтой” гэснийг “хохиролтой” гэж, төслийн 9, 37, 45, 49, 53, 54, 58 дугаар зүйлийн гарчиг болон холбогдох хэсэг, заалтад тусгагдсан худалдан авах ажиллагааны болон өрсөлдөөний асуудал “эрхэлсэн” гэснийг тохиолдол бүрд “хариуцсан” гэж, төсөлд тусгагдсан “энэ зүйлийн” гэснийг тохиолдол бүрд “энэ хуулийн” гэж тус тус өөрчлөх;

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “уг ажиллагаанд” гэснийг, 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалтын “эрх бүхий” гэснийг, 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын эшлэлийг, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “тохиолдолд” гэснийг, 22 дугаар зүйлийн 22.10 дахь хэсгийн “санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тогтоосон” гэснийг, 48 дугаар зүйлийн 48.2.13 дахь заалтын “эрх, үүрэг” гэснийг, 49 дүгээр зүйлийн 49.4.14 дэх заалтын “чиг үүрэг” гэснийг, 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсгийн “болон бусад” гэснийг, 53 дугаар зүйлийн 53.2 дахь хэсгийн “зохих” гэснийг, 55 дугаар зүйлийн 55.1.7 дахь заалтын “тоо баримт,” гэснийг, 56 дугаар зүйлийн 56.8, 56.12 дахь хэсгийн “худалдан авах ажиллагааны” гэснийг болон 56.8 дахь хэсгийн “тушаал гаргаж,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	5
Бүгд:	11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 5.2 дахь хэсэг нэмэх:

“5.2.Эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авахад энэ хуулийн хэмнэлттэй байх буюу бага үнийг сонгох аргыг хэрэглэхгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд саналаа тайлбарлаж үг хэлэв.

Зөвшөөрсөн:	5
Татгалзсан:	6
Бүгд:	11

45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “мөрдөгдөхөөс” гэснийг “болохоос” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “бүртгэлд бүртгэгдсэн этгээд бүртгэлийн үлдсэн хугацаагаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэлтэй” гэснийг “бүртгэл хүчинтэй хэвээр” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Зөвлөлдөх санал асуулгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “34 дүгээр” гэснийг “33 дугаар” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийн нэрийн “хуульд өөрчлөлт оруулах” гэснийг “хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийн нэрийн “хуульд өөрчлөлт оруулах” гэснийг “хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийн нэрийн “хуульд өөрчлөлт оруулах” гэснийг “хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийн нэрийн “хуульд өөрчлөлт оруулах” гэснийг “хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7. Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийн нэрийн “хуульд өөрчлөлт оруулах” гэснийг “хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: 1. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 112 дугаар зүйлийн 112.10 дахь хэсгийн “цахимаар татан авч” гэснийг “цахимаар авч” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн дугаарыг “4” гэж өөрчлөн, төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмж, үүнтэй уялдуулан төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын “62.1.5 дахь” гэснийг “62.1.4 дэх” гэж, төслийн нэрийн “нэмэлт” гэснийг “нэмэлт, өөрчлөлт” гэж тус тус өөрчлөх:

“3 дугаар зүйл.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.4 дэх заалтын дугаарыг “62.1.5” гэж өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “хэсгийн” гэсний дараа ““Шинжээчийг сонгохдоо” гэснийг “Шинжээчийн” гэж,” гэж, “өөрчилсүгэй” гэсний өмнө “тус тус” гэж, “тусгаж,” гэсний дараа “түүнийг” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн дугаарыг “2” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн дугаарыг “3” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг болон төслийн нэрийн “нэмэлт,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн дугаарыг “1” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн дугаарыг “2” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

11. Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Даатгалын тухай хуулийн 6¹ дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 6^{1.4} дэх хэсэг нэмсүгэй:

“6^{1.4}. Даатгагч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гаргах баталгааны үнийн дүн даатгалын нөөц сангийн энэ хуулийн 6^{1.1}-д заасан баталгаанд хамаарах эрсдэлийн сангаас хэтэрсэн бол давхар даатгалд хамрагдаж, эрсдэлийн үнэлгээ хийсэн байхыг шаардана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын сүүлийн 15 жилийн төсвийн бодлого, төсвийн тэнцэлд дүн шинжилгээ хийх, цаашид баримтлах төсвийн бодлогын талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн дүгнэлттэй танилцах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төлбөрийн тэнцлийн хэлтсийн дарга Б.Мөнх-Эрдэнэ, мөн яамны Худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын ахлах мэргэжилтэн Н.Энхцацрал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Ажлын хэсгийн танилцуулгыг Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Х.Булгантуяа нар үг хэлэв.

Г.Тэмүүлэн: “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 56 минут үргэлжилж, 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр 11 цаг 17 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим 09 цаг 21 минут

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хороонд оролцож байгаа гишүүдийг та бүхэнд танилцуулъя.

Хавдисламын Баделхан,
Жигжидийн Батжаргал, Жамбын Батсуурь,
Цэрэнпилийн Даваасүрэн, Болдын Жавхлан,
Бөхчулууны Пүрэвдорж, Шатарбалын Раднаасэд,
Цэндийн Сандаг-Очир, Дуламдоржийн Тогтохсүрэн,
Ганзоригийн Тэмүүлэн гээд нийт 10 гишүүн хүрэлцэн ирснээр өнөөдрийн ирц бүрдсэн байна. Ингээд 2023 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн хуралдаан нээснийг та бүхэнд мэдэгдье.

Хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээр асуудал. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хоёр. Монгол Улсын сүүлийн 15 жилийн төсвийн бодлого, төвийн тэнцэлд дүн шинжилгээ хийх, цаашид баримтлах төсвийн бодлогын талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн дүгнэлттэй танилцах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Байнгын хорооны тогтоолын төсөл.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж санал хэлэх гишүүд байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд /Засгийн газраас 2022.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Сангийн сайд Болдын Жавхлан, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Ганболдын Гийхнаран Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн дарга, Цэдэнбалын Батзул Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга, Даваадоржийн Номингэрэл Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн мэргэжилтэн, Түмэнжаргалын Энхжаргал Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн мэргэжилтэн гэсэн байна.

Төсвийн байнгын хорооны 2023 оны 11 дүгээр тогтоолоор байгуулагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Төсвийн байнгын хороо болон чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг холбогдох хуулийн төслүүдийг хэлэлцэж зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг бэлтгэн Төсвийн байнгын хороонд ирүүлсэн байна.

Хуулийн төслүүдийн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Сандаг-Очир гишүүн танилцуулна. Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг болон дэд ажлын хэсэг нийтдээ 10 удаа хуралдлаа.

Ажлын хэсэг, ажлын дэд хэсгээс бэлтгэсэн болон ажлын хэсгийн гишүүд Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо, түүнчлэн салбарын яам, агентлаг, төрийн бус байгууллагаас ирүүлсэн нийтдээ 70 гаруй саналыг санал нэг бүрээр хэлэлцэн хуулийн төсөлд тусгах, эсэх асуудлыг судалж ажлын хэсгийн хурлын үеэр 29 саналыг гишүүдээс гаргасныг хэлэлцэн саналын томъёололд оруулан ажиллаа.

Ажлын хэсгээс дараах зарчмын өөрчлөлтийг хуулийн төсөлд тусган зохицуулах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

1.Монгол Улсыг гадаад улсад сурталчлах Засгийн газрын үйл ажиллагаатай холбоотойгоор зөвхөн гадаад улсад бараа, үйлчилгээ худалдан авах тохиолдолд энэ хуулийн үйлчлэлд хамаарахгүй байхаар энэ хуулиар зохицуулах асуудлын хүрээ хязгаарыг нарийвчлан тогтоож, тусгах,

2.Төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд орон нутгийн төсвийн бүх байгууллагын зарласан тендер шалгаруулалтад тухайн орон нутгийн хуулийн аж ахуйн нэгжүүд давуу эрх олгох,

3.Хуулийн төслийг өргөн барьсны дараа буюу 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Улсын Их Хурлаас Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг баталснаар төсөлд тусгагдсан зарим зохицуулалт уг хуульд тусган батлагдсан тул эдгээр давхардсан агуулгатай зохицуулалтыг хасах,

4.Захиалагч, гүйцэтгэгчид урьдчилгаа төлбөр олгох нөхцөлийг илүү тодорхой болгож найруулах,

5.Худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх худалдан авах ажиллагааны нэгжийн эрх, үүргийг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэх, худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас төрийн бус байгууллагад шилжүүлж болох, зарим чиг үүргийг илүү нарийвчлан зохицуулах,

6.Үнэлгээний хорооны зохицуулалт, зохион байгуулалт, бүрэлдэхүүний талаарх холбогдох зохицуулалтыг тодорхой болгох,

7.Хуулийг 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тогтоох зэрэг болно.

Дээрх зарчмын саналууд болон хуулийн төслийг бусад хууль, тогтоомжтой нийцүүлэх, нэр томъёог жигдлэх зэргээр бэлтгэсэн зарчмын зөрүүтэй болон найруулгын шинжтэй асуудлуудыг Та бүхэнд хүргүүлээ.

Ажлын хэсгээс бэлтгэсэн саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгийн ахлагч Сандаг-Очир гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар санал хураалтыг явуулж эхэлье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

Санал хураалтыг явуулъя. Санал хураалт. 60 хувиар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэх бөгөөд гишүүн хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас болон бусад оролцогчдоос асууж болно гэж заасан байгаа.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр энэ өнгөрсөн жилийн төсвийн тухай хуулиар төсөв батлагдангуут шууд тендер зарлаж болохоор ийм зохицуулалтыг хийсэн байгаа. Өөрөөр хэлбэл 1 сарын 1 гаргаж байгаад тендер шалгаруулаад явдаг биш, 11 сарын төсөв батлагдсан өдрийн маргаашаас эхлээд тендер шалгаруулаад явах боломжтой. Тэгэхээр энэ жилийн хувьд бол Монгол Улсын хэмжээнд 2 шинэ хөрөнгө оруулалт тавигдсан гэж байгаа боловч Ховд аймагт бас нэг хөрөнгө оруулалтыг тавьж чадсан юм. Нийтдээ 2 тэрбум төгрөгөөр орон нутгийн сумдын үйл ажиллагааг сайжруулах тэр төслийн хүрээнд хөрөнгө тавьсан. Ховд аймагт ганцхан ширхэг тендер байгаа. Гэтэл өнөөдрийг хүртэл тэр тендер нь шалгарахгүй яваад байдаг. Тэгээд би өнгөрсөн 7 сарын 15-аас 9 сарын 20 хүртэл бараг 60 гаруй уулзалтыг малчидтайгаа хийсэн. Тэр малчдаасаа нэг зүйлийг л асууж явсан юм байгаа юм. Ингээд 4 сар, 5 сарын үед үүл буудах юм бол илүү жосоохон чийгшилт аваад тэрнээсээ чийгшилтийнхээ үндсэн дээр чийгээ татаад бороо ороод байх боломжтой юм байна. Тийм учраас ямаа самнахаас өмнө буудчихъя. Яагаад гэвэл 6, 7 сард чинь ер нь Оросууд тэр чигээр нь, Казакстанууд тэр чигээр нь үүл буудаад наашаа хоосон сэмжин үүл орж ирдэг. Тэндээс ямар ч бороо ордоггүй.

Тэгэхээр энэ 4 сар, 5 сард л сайн буудъя гээд жил болгон л Ховд аймагт 20 сая төгрөгийн үүл бууддаг сум өгдөг юм байна л даа. Тэрийг нь 100 сая төгрөг тусдаа 100 сая болгоод өгсөн чинь өнөөдрийг хүртэл тендер нь байхгүй, тэрнээсээ болоод Ховд аймагт ямар ч цас байхгүй, юу ч байхгүй ингээд хохирч байна л даа.

Тийм учраас энэ дээр манай орон нутагт тендер шалгаруулахдаа тодорхой хугацаа тавьдаг. Тэр нь дотроо багтааж ажлаа хийдэг ийм зүйлийг энэ хуульд тусгахгүй бол болохгүй байгаад байна. Энэ талаар ямар зохицуулалт орсон бэ гэдэг.

Г.Тэмүүлэн: Асуултад ажлын хэсгээс хариулъя. 2 номер.

Ц.Батзул: Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Ажлын дэд хэсгийн гишүүн Батзул. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу бол захиалагч төсөв батлагдсан даруйд худалдан авах ажиллагааг зохион байгуулах үүрэгтэй байгаа.

Сайдын багцад батлагдсан төсөл арга хэмжээг бол Засгийн газрын тогтоолоор Төрийн худалдан авах ажиллагааны газар эсвэл орон нутгийн эрх шилжүүлэх асуудлыг нь хуулийн төсөлд тодорхой заасан. Тэгэхээр таны хэлж байгаагаар төсөв батлагдсан даруй худалдан авах ажиллагаа зохион байгуулах бүрэн боломжтой байгаа хуулийн төслөөр. Мөн өнгөрсөн онд баталсан Төрийн хэмнэлтийн тухай хуулиар бүх төсөл, арга хэмжээнүүдийг 5 сарын 31-ны дотор худалдан авах ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх зохицуулалтын хүрээнд бол төсөв батлагдсан даруйдаа тендер шалгаруулалтыг явуулаад яг таны хэлж байгаагаар дулааны улирал эхлэхээс өмнө гүйцэтгэгч нь шалгарах бүрэн боломжтой байгаа.

Нөгөө талаар барилга байгууламжийн төсөл арга хэмжээний хувьд техник эдийн засгийн үндэслэл болон зураг төсөл нь сүүлийн 2 жилийн хугацаанд батлагдсан, магадлагдсан зураг төсөл дээр үндэслэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр Төсвийн тухай хуульд оруулсан байгаа. Одоо тэгэхээр цаашидаа худалдан авах ажиллагаа бол дулааны улирал эхлэхээс өмнө бүрэн хийгдээд дуусах боломжтой гэж үзэж байгаа. Нөгөө талаар тендер шалгаруулалтын зарлаад 30 хоног хүлээдэг байсныг нь бид нар богиносгож ажлын 15 хоног болгон багасгасан. Үүгээрээ бас хүлээж авах хугацаа болон тендер зохион байгуулах хугацаа маань багасаж байгаа.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Хариулт хангалттай юу. Хуулийн төслийн 2 дугаар зүйлээр санал хураалт явуулъя. Санал хураалт. 66.7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Пүрэвдорж гишүүн асуулт асууна гэж байна. Пүрэвдорж гишүүний микрофон.

Б.Пүрэвдорж: Яг энэтэй холбоогүй нэг өөр асуулт байна. Тэгэхээр тухайн харьяалсан сайд нь буюу эсвэл Засгийн газрын Хэрэг эрхлэх газар ч юм уу. Аль эсвэл Засгийн газрын тогтоолоор орон нутагт зарлагдах ёстой тендерийг аймаг руу нь шилжүүлдэг. Аймаг руу нь шилжүүлэхээр цаашаа бас сум дээр хэрэгжих бас нэг юу байдаг юм 200 сая, 300 сая төгрөгийн тендерүүд байдаг. Тэрийг сум руу шилжүүлье гэхээр болдоггүй. Тэгэхээр тухайн аймаг дээр тендерийг нь шулгаруулахаар ямар ч сэтгэлгүй нөхөд очоод ажлыг нь зүгээр гурилдчихаад буцаад явчихдаг. Гэтэл сум, орон нутгийн хүмүүс нь илүү сумаа гэсэн сэтгэлтэй тэр хүмүүсээр ажлаа хийлгээд, тэр ажлаа чанартай хийлгэх сонирхол бас байдаг. Яагаад гэвэл тэндээ амьдарч байгаа хүн дахин олон жил тэр

хүмүүсийн нүүрийг харж амьдрах учраас тэр сумын ажил хийж байгаа хүмүүс бол сумдаа чанартай ажил хийх байхгүй юу даа. Гэтэл энэ ажлыг аймгаас очсон хүмүүс будилуулчихаад дарга нарт нь тендерийн чанар хангахгүй байна гээд сумынх нь хүмүүс ярихаар дээгүүр нь тэр аймгийн удирдлагатай нь яриад бүгдийг нь хүлээгээд авчихдаг. Ийм тохиолдлууд маш их байгаад байна. Тэгэхээр яг энэ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай энэ хуулиар яг тэр аймаг руу шилжээд, аймаг руу шилжсэнээ цаашаа дахиад сум руу өгөх зохицуулалт ямар байна вэ. Яагаад гэвэл аймгийн удирдлагууд бол сум руу өгөх сонирхол байдаггүй. Яагаад гэвэл тендерийнхээ хэдэн хувийг цохих санаатайгаар аймагтаа авч үлддэг. Тийм учраас энэ асуудлыг зохицуулах хэрэгтэй байна. Яагаад гэвэл сум чинь бүгдээрээ нэг нэгнээ харж байдаг. Эндээс хэдэн төгрөг авсан юм гээд л ярьдаг учраас арай илүү чанартай хийж магадгүй л гэж би бодоод байгаа юм л даа. Энэ тал дээр хариулт авъя.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсэг асуултад хариулъя. 3 номер. Энхболд.

З.Энхболд: Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга Энхболд. Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих ажлыг холбогдох салбарын сайд нь эрх шилжүүлж байгаа тохиолдолд зөвхөн Төсвийн тухай хуулиараа аймагт шилжүүлж байгаа. Аймаг бол Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан төсөл, арга хэмжээний эрхийг тухайн орон нутагт хэрэгжих сумын Засаг дарга руу аймгийн Засаг дарга эрх шилжүүлэх нь нээлттэй байгаа. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар суусан ажлыг аймаг руу шилжүүлээд аймгаасаа дахиад шилжүүлэх ийм зохицуулалт Төсвийн хуулиараа бол боломжгүй байгаа. Өнөөдрийн сумын түвшин дэх боловсон хүчний асуудал дээр бол энэ

одоохондоо эрсдэлтэй байгаа. Тендер шалгаруулалтыг зохион байгуулах хүний нөөц, чадамжийн хувьд.

Г.Тэмүүлэн: Хариулт хангалттай юу. Нэмж тодруулъя. Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Аймаг бол тодорхой хэмжээний 200, 300 сая төгрөгийн өөрийн орон нутгийн төсвөөсөө хөрөнгө аваад тэрийгээ шилжүүлдэг. Гэтэл улсын төсөв дээр 200 сая төгрөгийн хөрөнгө тавигдсан. Тэрийгээ сум руу шилжүүлбэ гэхээр тэр нь болдоггүй. Тийм учраас энийг ирэх жилийн Төсвийн тухай хуулиар энд сум руу шилжүүлж болох тухай нэг заалт оруулаад шийдэж болох уу.

Г.Тэмүүлэн: Асуултад хариулъя. 3 номер.

3.Энхболд: Хуульдаа нэмэлт өөрчлөлт оруулаад явах юм бол мэдээж болно. Гэхдээ аймагт зохион байгуулахаар 10 хувийг завшаад байна гэдэг. Сумд очихоор 10 хувийг завишгүй гэсэн ийм баталгаа байхгүй л дээ.

Г.Тэмүүлэн: Раднаасэд гишүүн.

Ш.Раднаасэд: Тендерт ялчхаад хөрөнгө оруулалтаар барилга барина гэхээд алга болчихдог юм байна. Олон жил яригдаж байна. Энэ чинь дандаа орон нутагт зарлагдсан тендерүүд дээр явагдаад байдаг юм байна лээ дээ. Манай дээр гэхэд 2 сум дээр 2 цэцэрлэг байна. Халиун сум, Алтай сум гээд. Нэг бол бүр 2017 онд алга болсон. Тэгээд танайханд хандахаар худалдан авах ажиллагааныханд хандахаар захиалагчид нь бид нар бичиг явуулсан. Захиалагч нь болохоор хар жагсаалтад оруулчихсан гээд ингээд хаячихдаг. Тэгээд цаашаа явдаггүй. Үүний араас яг хэн хөөцөлдөх ёстой юм. Захиалагч нь гэхээр эд нар чинь тийм юм хийж чадах ч үгүй. Боловсролын яам бол тийм юмны араас

явдаггүй юм байна. Бичиг бичээд хаячихдаг. Энийг чинь яаж зохицуулах вэ.

Тендер зарладаг. Төсөвт өртөг хүрэхгүй байна. Тендерт оролцогч байхгүй байна гээд 2, 3 зарлаад аргагүй эрхэнд зургийг нь багасгадаг юм уу эсвэл гадна дэд бүтцийнх нь шугамыг нь хасаад батлаад өгчихдөг. Ингээд нэг нөхөр гарч ирдэг. Байшин барьчихдаг, шугам байдаггүй. Байр ашиглалтад орчихсон байдаг. Тэр шугам нь хойноос нь явж байж бараг 2 жилийн дараа ашиглалтад орж байх жишээтэй. Энэ юмаа хаасан уу. Энэ дотор хийсэн үү. Иж бүрнээр нь явуулах юм. Ийм 2 асуулт байна.

Гурав дахь нь гүйцэтгэл дээр гарын үсэг зурна гэж орон нутаг дээр замхруулж байна. Өөрсдөө шаврын үйлдвэртэй, бетон зуурмагийн. Тэндээс бетон авахгүй бол гүйцэтгэл зурдаггүй. Өөрсдөө ямар нэгэн байдлаар барилгатай холбоотой сонирхлын зөрчилтэй хүмүүс тэр дотор нь байдаг. Тэгээд барилгын компаниуд нь бүх юмаа дууссаны ар дээр танайх бол ийм юм байна гэдэг юмаа ярьдаг. Тэгээд энийг одоо яах юм. Гүйцэтгэл дээр хугацаагаар шахаад тэр гүйцэтгэлийг хугацаанд нь болно, болохгүй гэдэг юмаа хийгээд болохгүй бол болохгүй гэдэг бичгээ өгөхгүй, зурах гээд ч байгаа юм шиг, зурахгүй ч гээд байгаа юм шиг. Гүйцэтгэл зурдаг ажил чинь сүүлдээ бол бүх аймгууд, орон нутаг дээр ижилхэн шүү. Конторт зурагдахаа байсан шүү. Энэ хаа нэгэн газар машин дотор зурагддаг. Хаа нэгэн газар айлын гэрт зурагддаг болчихоод байгаа шүү. Одоо энэ хулгай зэлгий юм яригдаад байгаа. Тендерийн юмыг ухааж үзмээр байгаа юм. Бүхэлд нь. Үүний цаана юу явж байгаа бол. Ялангуяа өндөр өртөг бүхий. Тэгээд төсөвт өртгөө дахин дахин нэмүүлдэг. Оруулж ирж. Одоо бол Төсвийн хууль дээр бид нар тэр магадлалгүй бол явуулахгүй гээд нэг юм хийчихсэн. Түүрүүгээрээ хумигдах болов уу гэж бодогдоод байгаа юм. Энэ төсөв

тойрсон, тендер тойрсон хүрз байхгүй мөртөө тендер авчихсан. Одоо эмнэлгээ барьдаггүй. Сум дээр нэг нөхөр цүнхтэй шугамын автобусаар оччихоод, хүний машинд дайгдаж оччихоод би барина гээд Засаг даргад нь хэлчхээд яваад байдаг. Пүрэвдорж гишүүний хэлж байгаа үнэн. Энэ бол яг өөр аймгуудаас орсон, өөр аймагт ажилладаг компаниуд байгаа байхгүй юу. Тухайн аймгийн биш. Тэгээд урьдчилгаа байдлаар хэдэн төгрөг аваад, идээд явчихсан. Одоо бүр алга болчхож байна шүү дээ. Хүн нь байгаа эсэх нь мэдэгдэхгүй. Энэ юмнууд энэ дээр хэр хаагдсан байгаа вэ. Одоо энэ 8 дугаар зүйл дээр чинь. Ийм асуулт байна.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсэг хариулъя. 3 асуулт асуулаа. Эхний асуудал бүр тодорхой асуулт асууж байна. Говь-Алтай аймгийн Халиун суманд авсан гээд. “Баян могод” гээд компани байгаа байх. 2, 3 тендер тухайн жилдээ 2, 3 цэцэрлэгийн асуудал авсан байгаа. Асуултуудад тодорхой хариулъя. 2 номер.

Ц.Батзул: Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Батзул асуултад хариулъя. Хар жагсаалтын хувьд хуулиараа захиалагч нь байгуулсан гэрээнийхээ хэрэгжилтэд нь хяналт тавих үүрэгтэй байгаа. Хэрвээ гүйцэтгэлд нь асуудал гарах юм бол энэ талаар худалдан авах ажиллагааны улсын байцаагчид мэдэгдээд Улсын байцаагч дүгнэлт гаргаж, алдаа дутагдлыг залруулах эрхтэй байгаа. Раднаасэд гишүүний хэлсэн “Баян могод” гэдэг компанийн хувьд би өөрөө улсын байцаагчаар ажиллаад дүгнэлт гаргаад, хар жагсаалтад оруулсан байгаа. Одоо бол тендер шалгаруулалтад орохгүй байгаа. Өнөөдрийн байдлаар хар жагсаалтад нийт 46 аж ахуйн нэгж орсон. Цаашидаа энэ хяналт шалгалтыг сайжруулах үүднээс хуулийн төсөл дээр бид нар 48 дугаар зүйл. Захиалагчийн эрх үүрэг хэсэг дээр энэ байгуулсан гэрээний гүйцэтгэлийг нь олон нийтэд ил тод

байнга хөтөлж явуулна. Хэрвээ алдаа дутагдал гарах юм бол энэ талаар нь санал, хүсэлт гаргах эрх зүйн орчныг бий болгосон. Мөн нөгөө талдаа улсын байцаагч болон бусад хяналтын байгууллагууд нь гэрээний хэрэгжилттэй холбоотой хяналтыг тавихаар хуулийн төсөлд тусгасан байгаа.

Хоёрт нь болохоор төсөв бүрдэхгүй асуудал дээр нөгөө талдаа яг худалдан авах ажиллагааны харилцаанаас өмнө буюу төсөв батлах үед дутуу төсөв баталдгаас болж нэлээдгүй алдаа, дутагдал гардаг байсныг энэ жилээс залруулъя гээд явж байгаа. Одоо бол нийт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний 86 хувийг энэ ондоо багтаагаад дуусгая. Энэ онд шинэ ажил эхлүүлэхгүй байхаар улсын төсвийн хөрөнгө оруулалт дээр тавьсан. Цаашидаа яг төсвийн тухай хууль дээр нэмэлт, өөрчлөлт оруулаад сүүлийн 2 жилийн хугацаанд л батлагдсан зураг төсөв, магадлалтай төсөл арга хэмжээ дээр улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад багтаад хуулийн хүрээнд энэ цаашидаа алдаа дутагдал гарахгүй байх гэж төлөвлөн ажиллаж байгаа.

Гүйцэтгэл дээр гарын үсэг зурдаггүй асуудал. Улсын комисс чанаргүй барилгын асуудлаар бид нар ажлын хэсэг Барилга, хот байгуулалтын яамтай уулзаад энэ талаар бол яг гэрээний харилцаа нөгөө талдаа барилгын хууль тогтоомжийн дагуу зохицуулах харилцаа байна гээд тэгээд Барилга, хот байгуулалтын яам дээр ажлын хэсэг гарчихсан комисст хүлээж авах барилгын гүйцэтгэлд хяналт тавих асуудлыг нь тусгайлсан ажлын хэсэг Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах холбогдох журам заавраа шинэчлэхээр ажиллаж байгаа гэж салбарын сайд болон яамны холбогдох албан тушаалтан мэдэгдсэн.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр ажлын

хэсгээс 1 сана байгаа. Саналыг танилцуулъя.

3 дугаар зүйлтэй холбогдуулж: Төслийн 3 дугаар зүйлийн 3.3.6 дахь заалтын “сурталчлах” гэснийг “сурталчлахтай холбоотойгоор гадаад улсаас бараа, үйлчилгээ авах” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир, Батжаргал, Батсуурь, Даваасүрэн, Пүрэвдорж. Цаашид ажлын хэсэг гэх. Санал хураалт. 66.7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Санал хураалт. Санал хураалт 83.3 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Раднаасэд гишүүн саналтай.

Ш.Раднаасэд: Худалдан авах ажиллагааны энэ зарчим дотор нэг зүйл зөрдөг юм байна лээ. Одоо энэ эм, эмнэлгийн хэрэгслүүд дээр хамгийн бага үнийн зарчмаар гэдгээр явахаар хамгийн чанаргүй нь орж ирдэг. Яг ижилхэн нэртэй 2 өөр үнэтэй. Яг ижилхэн нэртэй, ижилхэн үйлчилгээтэй гэж байгаа мөртөө тэгээд тэр хүний биед үзүүлж байгаа тэр эмээс болоод хамраач байгаа тэр хоруу чанар нь бол хямдхан нь хэд дахин илүү. Одоо та бүхэн энэ хавдрын эмнэлэг дээр тарьдаг химийн тариануудыг нэг хүнд хийж байгаа cisplatin гэдэг тариа 60 мянган төгрөгийн үнэтэй. Улсын төсвөөр худалдаж авч байгаа үнэ нь. Тэрнээс 2-3 тариулаад хүн бүх биеийн үс унана. Бүх биед үзүүлэх хордлогын шинж илэрнэ. Тэгэхэд өөр улсад хэрэглэж байгаа тэрийг аваад тарихад тийм хэмжээний хордлого өгөхгүй. Тэгээд энийгээ та нар чанартайг аваач гэхээр хамгийн бага үнийн дүнтэй зарчмаар орж ирж байгаа нь энэ. Бид нар илүү чанартайг нь авъя гэхээр манай үнэ бага байтал өндөр

үнэтэйг нь эд нар авчихлаа гээд гомдол гаргаад шүүхдэж явж байгаад ингээд энийг ав гээд ороод ирдэг. Энэ эмийн үйлдвэр яг энэ зарчим чинь үйлчлэхгүй, эм эмнэлгийн хэрэгсэл дээр үйлчлэхгүй гэдэг юм бичиж өгөхгүй бол одоо бид нар эмийн үнэ шинэчлээд л яваад байгаа. Агентлаг нь байгуулагдаад, масс худалдан авалт хийнэ гээд л ингээд. Ялгаагүй дахиад энэ зарчмаар орохоор хамгийн хямд гэдэг дээр ороод дахиад хаагдчихаж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ 5 дугаар зүйлийн энэ зарчим дээр яг тэрийг л бид нар бодолцож оруулах хэрэгтэй. Одоо энэ хүнсний бүтээгдэхүүн ч гэсэн яг ижилхэн болно шүү сүүлдээ. Органик байх уу, органик биш байх уу. Энийг аль аль талд нь ашиглаж болохоор тийм болохуйц байдлаар бичиж өгөхгүйгээс болоод энэ дэр бас хүмүүс хохирох тал маш их байгаад байгаа юм байна лээ. Энийг ажлын хэсэг дээр ер нь ярьсан уу хоорондоо. Эмийн хуультайгаа явахаар энэ хуулийг хэрэглэх үү. Эм өөрийнхөө хуулийг хэрэглэх үү.

Г.Тэмүүлэн: Асуултад хариулъя. 2 номер. Батзул.

Ц.Батзул: Раднаасэд гишүүний асуултад хариулъя. Батзул байна. Эмийн чанарын асуудлаар сүүлийн 10 гаруй жил Монгол Улсад ярьж байгаа. Тендер шалгаруулалтаар шалгардаг эм Монгол хүний биед тохирдог, тохирдоггүй асуудал маргаантай байдаг. Тендерээр бага үнийн сонгодог. Тэгээд энэ нь эмийн чанар нь муу байдаг. Тэгээд энийг нь цаашид авахгүй байх асуудлыг нь бол Эрүүл мэндийн салбарынхан бүгд ярьдаг. Нөгөө талдаа энэ маань тендер шалгаруулалт гэдэг маань тухайн салбарынхаа хууль тогтоомжийн дагуу зах зээл дээр борлогдож, зарагдаж байгаа эмүүдээс шаардлага хангасан гэж үзээд оруулж ирж байгаагаас, санал болгосноос нь багийг нь сонгож байгаа санал. Түүнээс биш хямд үнэтэйг нь авдаг ийм юм байхгүй. Энийг бол Эрүүл мэндийн яамд бид нар удаа дараа хэлж

байгаа. Эмийн тавигдах стандарт, үйлдвэрлэх эрх олгодог зүйлээ эргэж харахгүй бол нэг талдаа эм үйлдвэрлэх зөвшөөрлийг нь өгөөд байдаг, нөгөө талдаа хэрэглэж байгаа хүмүүсээ чанаргүй эм хэрэглүүлээд байна гэдэг асуудал. Энэ бол цэвэр яг эрүүл мэндийн бодлогын асуудал хариуцсан яамныхан Эрүүл мэндийн яам нэг гараараа болохоор энэ эмийг үйлдвэрлэ гээд өгөөд байгаа. Нөгөө талдаа тэрийг хэрэглэхээр нь энэ муу эм байна гээд байгаа. Хэрвээ Монгол Улсын хууль, дүрмийнхээ дагуу стандартаа дээшлүүлээд сайн чанарын эм авдаг болох юм бол энэ дээр бид нар хямд үнийн асуудал ярихгүй. Цаашидаа зөвхөн Монгол иргэний биед нөлөөлөх чанартай эм л зөвхөн зах зээл дээр орж ирэх борлуулагдах эрхтэй болж чадах юм бол энэ бол тендер шалгаруулалт яг л тийм чанартай эм худалдаж авна гэж байгаа юм.

Тэгэхээр Раднаасэд гишүүний хөндөж байгаа асуудал дээр болохоор бид нар тухайн салбарынхаа стандарт, норм дүрмийг нь дээшлүүлэх шаардлага байна гэж үзэж байгаа юм. Цаашидаа бид нар нөгөө техникийн тодорхойлолтод тавигдах стандартуудыг нь заавал заах, мөн эм дээр тавигдаж болох шалгуур үзүүлэлтийг нь хангавал зохих доод шалгуур үзүүлэлтийг нь хуулийн төсөл дээр тодорхой зааж өгсөн байгаа.

Г.Тэмүүлэн: Раднаасэд гишүүн зарчмын зөрүүтэй санал гаргаж болно. Саналын томъёоллоо бичээд бичгээр гаргана гэсэн үг. Тэгвэл 5 дугаар зүйл дээр санал хураахгүйгээр эргээд сүүлд зарчмын зөрүүтэй санал гаргаад энийг хураагаад явъя.

Булгантуяа гишүүн асуулт асууя.

Х.Булгантуяа: Раднаасэд гишүүний саяны хэлсэн санал чухал санал. Засгийн газраас нэг ийм ажлын хэсэг гарж байгаа юм байна лээ Раднаасэд гишүүн ээ.

Эм, эмийн хэрэгслийн тухай хуулийг ер нь нэг шинэчилье. Үүний чанар, стандартын асуудлыг сая бол үнэнийг хэлэхэд бид нар батлахдаа бараг эм, эмнэлгийн хэрэгсэл дээр дотоодын стандарт энэ тэртэй байхаар баталчихсан шүү дээ. Тэгэхээр үүнийг шинэчилье. Олон улсын сайн стандартыг Монголд оруулж ирэхээр сайжруулъя гээд. Энэ тендерийн хууль дээр бид нарын хамгийн сайн, давхар авч үзэх ёстой юм нь нэгдүгээрт стандартын асуудлууд л юм байна лээ. Бид нар ажлын даалгавруудаа өгч чаддаггүй. Тэгээд ажлын даалгавраа олигтой өгч чадахгүй болохоор чанаргүй компаниуд ороод ирдэг. Тэгээд гэрээ байгуулаад яг л чанаргүй бараа бүтээгдэхүүнүүд нийлүүлдэг.

Хоёрдугаарт, энийгээ дагаад хэд хэдэн ялангуяа барилга дээр хэд хэдэн гэрээнүүд байдаг. Стандарт гэрээг нь Барилга, хот байгуулалтын яам, Сангийн яам тэгээд захиалагч яам ч билүү хамтдаа байгуулдаг стандарт гэрээг нь. Тэгээд тэр гэрээгээр бол дараа нь тэр компанитай ер нь шүүхдээд бараг төр засаг ялахааргүй гэрээ байдаг юм байна лээ. Тэгэхээр үүнийг дагаад ганцхан тендерийн хуулийг ярихаас гадна барилгын хуулийг давхар ярих ёстой юм байна лээ. Тэгэхгүй бол ерөөсөө Засгийн газар нь очоод яг үнэнийг хэлэхэд шүүхдээд ялагдахаар тийм гэрээг өөрөө байгуулчхаад дараа нь тэр барилгын компанийг бид нар гуйгаад ч барахгүй юм байна лээ. Та энэ ажлаа хийчхээч дээ гээд л ингээд суугаад байхад хэчнээн жил шүүхдэлцээд яваад байхаар тэр хооронд нь барилгынх нь үнэ яваад байхаар ийм болсон юм байна лээ. Ийм байдлаар нэг ажлын хэсэг Засгийн газар дээр гарчихсан ажиллаж байгаа.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Байхгүй тул дэмжигдсэн гэж ойлголоо.

Хуулийн 7 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Даваасүрэн гишүүн 7 дугаар зүйл дээр.

Ц.Даваасүрэн: Оролцогч, түншилэгчийн 7 дугаар зүйл дээр ерөнхий шаардлага дээр би нэг ийм зүйлийг анхаараач гэсэн юм аа. Тэгээд ажлын хэсэг дээр ярьсан боловч шийдэж чадаагүй яваад байгаа юм байна. Одоо маш өндөр үнэтэй станцын юм уу би зүгээр эрчим хүчээр жишээ авч байна шүү. 220кВт-ын дэд станцын тоноглолууд, станцын том тоноглолууд асар үнэтэй байхгүй юу. Тендер зарлахаар бүгдээрээ л гүйгээд орчхож байгаа юм. Ингээд эвдрэл гарангуут баталгаат хугацаанд эвдрэл гарангуут төлж чадахаа байчихдаг. Би 2 жишээ хэлье. ТЭЦ-4 дээр 2 жишээ байгаа. 100мВт-ын трубин нийлүүлээ гэсэн тэр нь 100 биш 80 мВт гаргаад байдаг. Соль гэхээр сольж чадахгүй. Яагаад гэвэл тийм өндөр үнэтэй юмыг чинь чадахгүй шүү дээ. Энэ чинь бараг 100 сая долларын юм аваад хийчихсэн байгаа шүү дээ. Тэгээд ингээд үнэтэй юм нийлүүлдэг. Нийлүүлчээд дараа нь чанарын шаардлага хангахгүй болохоор нөгөөхөө сольж чадахаа болчихдог. Баталгаат хугацаандаа сольж чаддаггүй. Эрдэнэтийн 220кВт-ын дэд станц дээр мөн трансформатор нь техникийн гэмтэлтэй болчихсон. Тэгээд яг ийм тоноглолуудыг чинь техникийн гэмтэлтэй болчихоор тэрийг чинь хүлээж болдоггүй. Одоо жишээлбэл 1 жил, 2 жил юм уу тэрийг нийлүүлэхийг хараад суугаад байж болдоггүй. Яагаад гэвэл Эрдэнэтийн үйлдвэр зогсчих гээд байдаг. Тэгээд аргаа бараад улс буцаагаад ахиад худалдаж авч байгаа байхгүй юу. Ингээд байж болохгүй шүү дээ. Нийлүүлэхээ болохоор уургийн морь шиг давхиж орж нийлүүлчээд, гэмтэл гарахаар нь уучлаарай би энийг чинь төлж чадахгүй гээд сууж байдаг. Яг станц 220кВт-ын дэд станцын тоног төхөөрөмж дээр бол байгаа. Цаашидаа яах юм бэ гэж. Мөн ТЭЦ-4 дээр усны

хөргүүрийн систем дээр бас тийм юм болсон байгаа. Одоо болтол тэр байгууламж босоотой байж л байгаа. Тэрийг хэн ч ашиглахгүй байгаа. Гэтэл тэрийг соль гэхээр сольж чадахгүй шүү дээ. Нөгөө компани чинь тийм мөнгө байхгүй компани байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг ер нь цаашидаа яах юм. Одоо жишээлбэл 100 сая долларын трубин генератор соль гэдэг. Сольчихдог. Дараа нь эвдэрчихээр нь нөгөөхөө сольж чадахаа больчихдог. Ийм үнэтэй том тоноглолуудыг тендер зарлаад нийлүүлдэг. Тэгсэн мөртөө нөгөөдүүл нь буцаагаад техникийн гэмтэл гарчихаар сольж чаддаггүй. Би бол ямар зүйл хэлээд байсан гэхээр ийм тоноглолуудыг үнэтэй. Тухайн үйлдвэр авч нийлүүлдэг байх л хамгийн хямд тусна. Тэгээд тэр үйлдвэр чинь баталгаа гаргаж өгнө шүү дээ. Зарим нь үйлдвэр шууд нийлүүлдэггүй гэж худлаа яриад байдаг. Тийм юм байхгүй. Тэгэхээр ийм үнэтэй тоноглолуудыг ер нь яах юм бэ. Одоо ингээд улс хувийн компани нийлүүлдэг дараа нь чадахаа болохоор улс төлөөд явдаг. Ингээд л яваад байх юм уу. Нэг бол хаячхаж байгаа. Тэр ТЭЦ-4-ийн 2 бол хаячихсан байгаа шүү. Усны хөргүүрийн байгууламж, трубин генератор 100мВт гэхчхээд 80мВт гаргаад байгаа энэ блокийг бол зүгээр тэгээд л хаячихсан байгаа. Эрдэнэтийг бол худалдаж авч нийлүүлсэн байгаа. Нийлүүлсэн л дээ. Яагаад гэвэл тэр чинь Эрдэнэтийн район, Эрдэнэт үйлдвэр зогсчих гээд байгаа учраас тэр трансформаторыг улс худалдаж авч нийлүүлсэн. Ийм юмыг.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: 7 дугаар зүйлтэй холбогдуулж асуултад хариулъя. Оролцогчийн ерөнхий шаардлагыг магадлахтай холбоотой асуулт байна. Хэн хариулах уу. 2 номер. Батзул.

Ц.Батзул: Даваасүрэн гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсэг дээр энэ асуудлыг ярилцсан. Хуулийн төслийн 36 дугаар зүйлийн 1.6 дахь заалтад бол төрийн болон орон нутгийн өмчид болон

өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйлдвэрлэлд шаардлагатай тоног төхөөрөмжийн зарим хэсгийг солих засварлах үед үйлдвэрлэгчийг өөрчлөх нь захиалагч өөр төрлийн техникийн үзүүлэлттэй материал авахад хүргэх, ашиглалт болон засвар үйлчилгээнд техникийн хүндрэл учруулах нөхцөлд тухайн бараа, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэгчээс нь шууд худалдан авч болно гэдэг зохицуулалтыг нь тодорхой заасан байгаа. Хэрвээ гэрээ байгуулчихаад гэрээний үүргээ биелүүлэхгүй бол нөгөө талдаа хариуцлагын асуудал байгаа. Тэгээд хариуцлагын талаар бол хуулийн төсөлд тодорхой заасан байгаа.

Г.Тэмүүлэн: Даваасүрэн гишүүн тодруулъя.

Ц.Даваасүрэн: Энэ чинь гэрээний үнийн дүнгийн 20 хувиас хэтрэхгүй бол гэж байгаа шүү дээ. Энийгээ сайн анхаараарай. Тэгээд тэр компанид бол торгууль гээд тэр чинь нэмэр байхгүй юм байна лээ шүү дээ. Бид нар өчнөөн тэгж үзсэн. Тэр трансформаторыг нийлүүлэх мөнгө тэр компанид насаараа хөдөлмөрлөөд ч байхгүй байгаа юм чинь яах юм бэ. Тэгсэн мөртөө яагаад тэгээд нийлүүлчихдэг юм мэдэхгүй. Тэгэхээр энийг бол торгуулиар шийдэж чадахгүй. Тэр компани тийм мөнгөтэй байсан бол зүгээр аваад солиод нийлүүлчихнэ шүү дээ. Харамсалтай нь чадахгүй л байгаа байхгүй юу даа. Би хэлээд байна шүү дээ. 50, 60 сая долларын тэгээд 100 сая долларын ийм төхөөрөмжүүдийг нийлүүлдэг. Нөгөөх нь техникийн гэмтэлтэй болчихдог. Буцаагаад сольж чадахгүй. Би бүр хэлээд байна шүү дээ. 2 нь бол солигдоогүй хэвээрээ байж л байгаа. Одоо болтол байж л байгаа. АТГ шалгаж байгаад сүүлдээ залхаад хаядаг юм шиг байгаа юм. Эрдэнэтийнхийг бол.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Тодруулгад нэмж харуулъя. 2 номер. Батзул.

Ц.Батзул: Хуулиар тендер шалгаруулалтад ороход нь 3 үндсэн нөхцөлийг нь шалгаж байгаа. Энд бол тухайн аж ахуйн нэгж нь үйл ажиллагаа эрхлэх боломжтой юм уу.

Хоёрт нь болохоор туршилага, техникийн чадвар шаардлага хангаж байгаа эсэх

Гуравт нь санхүүгийн нөөц бололцоотой эсэх асуудлыг нь үзэж байгаа. Тэгэхээр анхнаасаа тавигдсан шалгуурыг хангаад ороод ирсэн гүйцэтгэгч маань гэрээгээр хүлээснийхээ дагуу тухайн бараа, ажил, үйлчилгээ нь шаардлага нийцэхгүй бол хариуцлага хүлээнэ. Энэ хуулиар бас гүйцэтгэсний дагуу төлбөрөө авч байгаа учраас хэрвээ гэрээний гүйцэтгэлд нь ямар нэгэн алдаа дутагдал гарах юм бол гэрээ болон хуульд заасны дагуу хариуцлага хүлээгээд явна. Нийлүүлсэн бараа нь ажиллахгүй болчихлоо гээд өөрөө явчихдаг ийм зохицуулалт бол байхгүй. Тэгэхээр санхүүжилт нь бол гүйцэтгэлд үндэслээд явж байгаа учраас ийм асуудал харьцангуй гайгүй болов уу гэж бодож байна.

Г.Тэмүүлэн: Даваасүрэн гишүүн нэмж тодруулъя.

Ц.Даваасүрэн: Уг нь бол тендерийн хууль дээр чинь борлуулалтын орлого нь тэд бол гэж явдаг л даа. Гэхдээ манайд ийм борлуулалттай компаниуд чинь байхгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр ийм худлаа тендер байх хэрэгтэй юм уу, үгүй юу гээд байна шүү дээ. Нийлүүлбэл хэдхэн компани л Монголд байгаа байх. 50, 60 сая, 100 сая долларын юмыг бол. Тэгэхээр энэ нэг асуудлыг шийдэхгүй бол зүгээр нэг тайлбараар торгууль ийм байх ёстой. Тийм шалгуур байх ёстой гээд аргалаад өнгөрч болохгүй. Энэ чинь амьдрал дээр тулгараад байгаа учраас би хэлээд байна шүү дээ. Тэгээд аргаа барахдаа сүүлдээ улс төлөөд байна шүү дээ. 40, 50 сая долларыг улс дахиад гаргаж байна шүү дээ. 2 гаргаж байна.

Эхээд эвдэрхий трансформаторт нь гаргаж байна. Дараа нь сольж чадахгүй болохоор нь ахиад худалдаж авч өгч байна. Тэгэхээр энэ бол болохгүй болоод байгаа юм. Энийг хэдүүлээ ямар нэг байдлаар шийдэхгүй бол үнэтэй.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Тайлбар 2 номер.

Ц.Батзул: Гэрээгээ гүйцэтгээгүй компанид нь хариуцлага тооцохгүйгээр дараагийн худалдан авалт хийдэг зохицуулалт хуулийн төсөлд байхгүй. Тэгэхээр анхнаасаа тендер шалгаруулалтад орж байгаа этгээд маань тэр хариуцлагаа үүрээд гэрээний үүргээ бүрэн биелүүлэх ёстой. Тэгээгүйгээ дахин нэмж тендер шалгаруулалт зарлаад, тэгээд хэрвээ тийм байх юм бол үйлдвэрлэгчтэй нь гэрээ хийгээд авах боломжийг нь хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.6-д заагаад өгсөн байгаа юм аа гишүүн ээ.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсэг дээр Даваасүрэн гишүүн санал гаргаад дэмжигдээгүй, унасан байна. Тэгэхээр та зарчмын зөрүүтэй санал гаргаж болно. Ойлголоо. Та эсвэл Даваасүрэн гишүүн зарчмын зөрүүтэй саналаа гаргаад хураалгуулж болно. Саяны асуудлууд дээр шийдэл.

Тэгвэл зарчмын зөрүүтэй санал алга байна. Гараагүй тул дэмжигдлээ гэж ойлголоо.

Хуулийн төслийн 8 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 8 дугаар дээр ажлын хэсгийн 1 санал байгаа. Энийг хураая.

Төслийн 8 дугаар зүйлийн 8.7.1 дэх заалтын “орон нутгийн өмчит,” гэснийг “орон нутгийн төсвийн байгууллага, орон нутгийн өмчит болон” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 9 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Байхгүй тул дэмжигдсэн гэж ойлголоо.

Хуулийн төслийн 10 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Байхгүй тул дэмжигдсэн гэж ойлголоо.

Хуулийн төслийн 11 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Дэмжигдсэн гэж ойлголоо.

Хуулийн төслийн 12 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Дэмжигдсэн гэж ойлголоо.

Хуулийн төслийн 13 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 13 дугаар зүйл дээр ажлын хэсгийн нэг санал байгаа. Саналыг уншиж танилцуулъя.

13 дугаар зүйлтэй холбогдуулж, Төслийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийн “баримтжуулж тендер шалгаруулалтын хувийн хэрэгт хадгална.” гэснийг “баримтжуулна.” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 91.7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 14 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Тендерийн хуулийг бид нар сайн хууль гаргах гэж байгаа юм бол сайн ярь л даа. Цоорхойтой битгий гаргаад байгаач ээ. Би хэлээд байна шүү дээ. Та нар мэдэж л байгаа шүү дээ.

Тагнуулын эмнэлэг дээр нэг том аппаратыг Хууль зүйн сайд нь аваачиж гаргана гэснээс болоод ашиглаж чадахгүй болсон биз дээ. Тэгээд ингээд байх юм. Үнэтэй төхөөрөмжүүдийг тэгээд яах юм. Тийм юм болсон шүү дээ. Нөгөөхийг нь хорих болгоно гэж нөгөө эмнэлгийн доор байсан том аппаратыг нь аваачиж гаргаснаас болоод нөгөөдөх нь дахиж ашиглагдахгүй болсон шүү дээ. Иймэрхүү маягаар байгаад байх юм бол би хэлээд байна шүү дээ энэ хууль чинь цоорхойтой л гарах юм бол тэгээд ямар ч хэрэггүй гээд байна шүү дээ. Хулгай хийдэг хүмүүс нь үнэтэй тоног төхөөрөмж дээр нь тендер хийгээд тэгээд Хятадын хувийн үйлдвэрийн юм оруулж ирчхээд дараа нь сольж өгөхөө байчихдаг. Энэ хуулийг чинь бид нар яагаад найруулж шинэчилж оруулж байгаа гэхээр өмнө гарсан цоорхойг байхгүй болгоё л гэж оруулсан хэрэг шүү дээ. Тэгээд энэ болохгүй байна гээд байхад чихнийхээ хажуугаар явуулаад байх юм. Тэгвэл яах гэж та нар энд хууль батлаад байгаа юм. Амьдрал дээр болохгүй байгаа юмыг чинь л хэлээд байна шүү дээ. Энийг яах вэ л гээд байна шүү дээ. Шийдэл гарга л даа.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгийн гишүүн Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Энэ дээр бол олон талаас нь ярьсан. Гэхдээ мэдээж амьдрал юм хойно янз бүрийн юм байгаа нь ойлгомжтой. Гэхдээ аль болохоор зохицуулалтынх нь асуудлыг тусгаад оруулсан. Тэр 36.1-ийн хэдээрээ энэ асуудал зохицуулагдаад байна гэж хараад байгаа. Ер нь бид нэг анхаарах ёстой юм байх шиг байна. Үнэтэй тоног төхөөрөмж, техник хэрэгслүүд дээр тендерийн даалгавар, техникийн нөхцөл тодорхой өгдөг тухай асуудлыг тодотгох тухай юм байна. Хоёрдугаарт тодорхой тэр мэргэжлийн шинжээчдийн багатай тэр ашиглагчийн хийгээд захиалагчийн ажлын хэсэг нь хяналтын ажлын хэсэг нь суурилуулахаас өмнө орж ирсэн техник дээрээ дүгнэлт гаргаад яг

мөн үү гэдэг дээр тусгайлсан акт үйлдэж байж сая суурилуулдаг энэ үйл явц руу нь нэг заалтаар зохицуулалт хийж болох асуудал байгаа юм шиг байна. Энэ талаас нь манай ажлын хэсэг бас нэг анзаарч үзвэл болох болов уу гэж ингэж харж байна. Ер нь энэ бол үнэ цэнтэй том тоног төхөөрөмжүүд дээр мэргэжлийн баг нь яг мөн байна. Үүнийг суурилуулж болох юм байна гэх юм бол тэгээд суурилуулж болдог тийм юмаар нь шийдэх ёстой. Тэгэхгүйгээр үйлдвэрлэгчээс авч ирээд суурилуулсны дараа жоохон явж байгаад энэ 100 гардаггүй 80 гардаг юм байна гэхээр ашигласан юмыг үйлдвэрлэгч буцааж авахгүй байгаа нь ойлгомжтой. Нөгөө нөхөр шинэчлэх асуудлаа шийдэж чадахгүй байгаа нь ойлгомжтой. Тэгэхээр суурилуулахаасаа өмнө тусгайлсан дүгнэлтээ гаргаж, актаа үйлдээд үе шатны ажлын акт гаргадаг шиг байдлаар үүнийг ингэж хуульдаа зохицуулах нь зөв юм шиг байна.

Г.Тэмүүлэн: Даваасүрэн гишүүн нэмж тодруулъя.

Ц.Даваасүрэн: Батжаргал гишүүний хэлээд байгаа ажлыг чинь улсын комисс нь уг нь хийж байгаа ухаантай шүү дээ. Бүгд байгаа байхгүй юу. Гүйцэтгэл нь ч гэсэн бүгд л байгаад байгаа юм л даа. Тэгсэн мөртөө тэр чинь нөгөө хувийн үйлдвэрийн хийсэн трансформатор нь гадна талаас нь хараад бүх юмыг нь яахаар бараг л яг л ижилхэн л юм байгаа байхгүй юу даа. Генератор ч гэсэн яг л ижилхэн юм байгаа. Тэр трансформаторын хувьд бол улсын комисс нь бараг авахгүй гэсэн юм байна лээ. Нөгөөдөх нь сольж чадахаа л больсон байхгүй юу. Өндөр үнэтэй учраас. Улсын комисс нь бараг авахгүй гэсэн юм байна лээ. Гэтэл сольж чадахаа л байсан байхгүй юу. Нөгөө компани нь. Тэр өндөр үнэтэй юмаа. Тэгэхээр яах юм бэ л гээд байна. Өндөр үнэтэй юмыг сольж чадахгүй шүү дээ. Одоо жишээ нь Батжаргал дарга ч гэсэн дундуур нь ингээд шалгалт хийж байгаад

тогтоолоо. Нөгөө нөхөр чинь худалдаад авчихсан байгаа байхгүй юу.

Г.Тэмүүлэн: Гишүүд та хэд тодорхой зүйл заалтууд дээр саналуудаа гаргаж болно. Ажлын хэсэг дээрээ та хэд маань сайн ярилцаад тодорхой санал, шийдлээ гаргаад оруулж ирээрэй. Хуулийн төслийн 14 дүгээр зүйлтэй холбогдуулаад зарчмын зөрүүтэй санал одоогоор гараагүй байна. Танилцлаа. Раднаасэд гишүүн.

Ш.Раднаасэд: Худалдан авах ажиллагааныхан хариулах ёстой байх. Одоо энэ тендерийн баталгаа, маргаан гаргагч барьцаа тавьж, дэнчин тавьж маргаж байгаа шүү дээ. Энэ чинь 20 тэрбум төгрөг дээр 20 сая төгрөг хүртэл гэж байгаа юм. 1 хувь хүрэхгүй хэмжээний баталгаа тавиад маргаан үүсгээд хаячихна байна шүү дээ. 100 тэрбум бол 60 сая ч гэдэг юм уу. Би бол харьцангуй өмнө нь бол маргаад, шүүхдээд бүх юмыг гацаагаад явчихдаг байсан юм чинь энийг дэнчин тавьснаас хойш, барьцаа тавьснаас хойш харьцангуй багассан гэж бодож байгаа. Одоо энэ мөнгөн дүнгээ та нар багасгасан уу. Үүний үр дүнг илүү сайжруулахын тулд мөнгөн дүнг нь өсгөх ёстой юу, үгүй юу. Яах ёстой вэ. Энэ мөнгөн дүнг би гайхаад байна л даа. Одоо 20 тэрбум төгрөгийн тендер авчхаад 20 хүртэлх сая гээд. 20 хүртэл гэхээр 20 хүртэлх нь 1 ч байж болох юм уу. Хэд байх юм мэдэхгүй. Энийг хэн тогтоох юм нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ 1 хувь орчим л байна л даа. 100 тэрбум дээр 40 сая гэхээр хэд ч болж байгаа юм. Мэдэхгүй. Энэ дээр нэг хариулт өгөөч.

Г.Тэмүүлэн: Батзул 2 номер.

Ц.Батзул: Раднаасэд гишүүний асуултад хариулъя. Хуулийн төслийн 14.7 дээр бол төсөвт өртөгтэй нь уялдуулаад хэрэв үндэслэлгүй гомдол гаргасан тохиолдолд хураах баталгааны хэмжээг

нь ялгамжтай тогтоосон байгаа. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн 20 дугаар зүйлд нь бол ямар ч төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтад орсон бай 20 сая төгрөгийг нь улсын орлого болгодог. Тэгээд жишээ нь 20 хүртэл сая төгрөгийг нь улсын орлого болгож байгаа. 2019 онд орсон нэмэлт өөрчлөлтөөс хойш нийт тендер шалгаруулалтын 15 хувьд нь гомдол гардаг байсан бол одоо тэр маань 3 хувь хүртэл буурсан байгаа. Үндэслэлгүй гомдлын тоо жил ирэх тусам буурч байгаа. Нөгөө талдаа үндэслэлгүй гомдол гаргах асуудлыг нь зохицуулах хүрээнд тендерт оролцсон нь шалгарсан компанийнхаа материалтай танилцаж байгаа. Одоо шинэчилсэн хуулийн төсөлд болохоор үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, үнэлгээний хорооны зөвлөмж, дүгнэлт, захиалагчийн шийдвэрийг бас оролцсон тендерт оролцогчид нь ил болгохоор хуулийн төсөлд заасан. Тэгэхээр цаашидаа бол үндэслэлгүйгээр гомдол гаргах асуудал тусгайлан багасах болов уу гэсэн хүлээлттэй байгаа. Нөгөө талдаа хуулиа дагуулаад Захиргааны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх журмын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан. Энд юу гэж зохицуулсан бэ гэхээр шүүхэд захиргааны хэрэг хянан шийдвэрлэх, ялангуяа тендер шалгаруулалттай холбоотой хэрэг хянан шийдвэрлэхдээ тендер шалгаруулалтын цахим системд байгаа материалын хүрээнд нь үзэх ийм шинэ зохицуулалтыг оруулсан. Тэгэхээр шүүх дээр материал цуглуулах асуудлаар хугацаа их алддаг. Бас их хойшилдог асуудал маань тодорхой хэмжээнд шийдэгдэнэ гэсэн бодолтой байгаа.

Г.Тэмүүлэн: Тайлбар хангалттай юу. Хуулийн төслийн 14 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, тайлбар авлаа. Зарчмын зөрүүтэй санал алга байна.

Хуулийн төслийн 15 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, тодруулга,

Алга байна. Хуулийн төслийн 35 дугаар зүйл дээр ажлын хэсгийн нэг санал байгаа. Саналыг уншиж, танилцуулъя.

Төслийн 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалтын Тайлбар хэсгийн “дуусах” гэснийг “дуусаж санхүүжилтийн эх үүсвэргүй болох” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт явуулъя. Санал хураалт. 75.0 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 36 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Танилцлаа.

Хуулийн төслийн 37 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Танилцлаа.

Хуулийн төслийн 38 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Танилцлаа.

Хуулийн төслийн 39 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Танилцлаа.

Хуулийн төслийн 40 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Танилцлаа.

Хуулийн төслийн 41 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Танилцлаа.

Хуулийн төслийн 42 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 42 дугаар зүйл дээр ажлын хэсгийн нэг санал байгаа. Саналыг уншиж танилцуулъя.

42 дугаар зүйлтэй холбогдуулж, Төслийн 42 дугаар зүйлийн 42.3.1 дэх

заалтын “банкны” гэсний дараа “, эсхүл Монгол Улсын даатгагчийн” гэж нэмэн, үүнтэй уялдуулж 42.3.3 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 75.0 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 43 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 43 дугаар зүйл дээр ажлын хэсгийн нэг санал байгаа. Саналыг уншиж танилцуулъя.

Төслийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“43.1.Тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу баталгаа гаргасан бол ажлын бэлтгэл хангахад зориулан гүйцэтгэгчид урьдчилгаа төлбөр төлнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58.3 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 44 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Байна. Раднаасэд гишүүн.

Ш.Раднаасэд: Энэ дээр л уг нь ажлын хэсэг их сайн ажиллах ёстой байсан байх. Бид нар сая Үйлдвэржилтийн байнгын хорооныхон гутлын үйлдвэрээр яваад байсан. Очиход тэндээс та нарт төрсөн сэтгэгдэл юу байсан юм. Одоо ингээд 12 сарын 01-н дотор ч гэдэг юм уу өвлийн хувцас гутал нийлүүлээч гээд Онцгой байдал, тусгай байгууллагууд хувцас захиалдаг. Тендер нь явсаар байгаад 6 сард дуусдаг. 4 сарын хугацаанд хэдэн мянган гутал хувцас хийж амждаггүй. Тэгээд Монголд үйлдвэрлэв гэдэг шошготойгоор Хятадаас оруулж ирээд өгчихдөг. Энэ дээр л тэр төлөвлөх гэдэг дээр 3 жилээр юм уу 2 жилээр тэр аж ахуйн нэгжид тендер өгмөөр байгаа юм. Эд нар чинь ажлаа жинхэнэ төлөвлөөд, зээлээ аваад, хүмүүсээ зохион байгуулаад, тэгэхгүй сүүлийн хэдэн сард нь 24 цагаар бүх

хүмүүсээ ажиллуулаад ингээд дуусгадаг. Эсвэл бүр барахаа байхаараа Монголд үйлдвэрлэв гээд Хятадаас оруулж ирээд өгчихдөг. Сурагчийн дүрэмт хувцас, онцгой байдал, тусгай байгууллагуудын хувцас, хэрэгсэл, хоол унд дээр ч гэсэн бид нар энийг 3 жилээр төлөвлөж тендер шалгаруулалт явуулж болох байхгүй юу. Энэ дотор байгаа юу. Энэ төлөвлөлт дотор чинь тэр чинь хийгдэж байж бид нар энэ дотоодын үйлдвэрлэлийг дэмжих юм.

Хоёрдугаарт энэ аж ахуйн нэгжүүдээ бодитойгоор юм чинь энэ дотор явагдах ёстой байхгүй юу. Тэгвэл энэ дотор байгаа юм байна тийм үү.

Г.Тэмүүлэн: Раднаасэд гишүүний асуултад хариулъя. Батзул 2 номер.

Ц.Батзул: Хуулийн төслийн 10.11 дэх хэсэгт захиалагч байнгын хэрэгцээтэй бараа, ажил, үйлчилгээний нэгж үнэ болон бусад нөхцөлийг 3 хүртэл жилийн хугацаанд тогтоох нөхцөлтэй тендер шалгаруулалт зохион байгуулж болно гэж заасан. Нөгөө талдаа бид хуулийн төслийн 8 дугаар зүйл дээр дотоодын бараа үйлдвэрлэгч нь импортын бараатай өрсөлдөхгүй зохицуулалтыг нь оруулж өгсөн. Дотоодын барааны жагсаалтыг нь Засгийн газар үйлдвэрлэлийн болон хүчлийн асуудал хариуцсан яамдын саналыг үндэслэн жагсаалтыг боловсруулж байгаа. Жагсаалтад багтсан Монгол Улсын гарал үүсэлтэй дотоодын бараа байх юм бол импортын бараатай өрсөлдөх шаардлагагүй. Нөгөө талаараа бид мөн нэмэлт хуулийн төслийн 37 дугаар зүйлд ерөнхий гэрээний арга гэж байгаа. Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа бүх төрийн байгууллагуудын хувьд нийтлэг өдөр тутмын бараа, ажил, үйлчилгээг 3 жилийн хугацаатай гэрээ байгуулаад цахим дэлгүүрээс нэгж үнээр нь худалдан авах боломжийг хуулийн төсөлдөө оруулсан. 2017 оноос хойш энэ ерөнхий гэрээний зохицуулалтын дагуу

нийтдээ Монгол Улсын цахим дэлгүүрт нь 500 орчим бараа, 900 орчим ерөнхий гэрээ байгуулагдсан. Эмнэлгийн хэрэгсэл болон мөн зарим компьютер тоног төхөөрөмж, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хэрэгсэл, сурах бичиг, тавилга, ширээг нь бол яг эндээс аваад явж байгаа.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Тайлбар хангалттай гэж үзэх үү. Асуулт асууж, тодруулга авлаа. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Танилцлаа.

Хуулийн төслийн 45 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Танилцлаа.

Хуулийн төслийн 46 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Танилцлаа.

Хуулийн төслийн 47 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Танилцлаа.

Хуулийн төслийн 48 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 48 дугаар зүйл дээр ажлын хэсгийн 1 санал байгаа. Саналыг уншиж танилцуулъя.

Төслийн 48 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 48.4.10 дахь заалт нэмэх:

“48.4.10.энэ хуулийн 13.4-т зааснаар баримтжуулсан гэрэл зураг, дүрс бичлэг;” Санал хураалт явуулъя. Гишүүд анхааралтай хандаарай. Санал хураалт. 63.6 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 49 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 49 дүгээр

зүйл дээр ажлын хэсгийн 5 санал хураана. Саналуудыг уншиж танилцуулъя.

1.Төслийн 49 дүгээр зүйлийн 49.4 дэх хэсгийн “энэ хуульд заасан” гэснийг “Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1-д зааснаас гадна” гэж, мөн зүйлийн 49.4.5 дахь заалтын “үйл ажиллагаатай холбоотой асуудлаар захиалагч, оролцогчийг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах,” гэснийг “ашиглалт, худалдан авах ажиллагааны талаар” гэж өөрчлөн, мөн зүйлийн 49.4.1 дэх заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах:

“49.4.1.цахим системийн үйл ажиллагаа, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлаар захиалагч, оролцогчийг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63.6 хувиар дэмжигдлээ.

2.Төслийн 49 дүгээр зүйлийн 49.4.10 дахь заалтын “судалгаанд үндэслэн” гэснийг хасаж, мөн заалтын “ерөнхий гэрээний аргаар худалдан авах бараа, үйлчилгээний нэгж үнийн дээд хязгаарыг тогтоох, ерөнхий гэрээний аргаар тендер шалгаруулалтыг зохион байгуулах” гэсэн чиг үүргийг 49.4.11 дэх заалт болгон салгаж, үүнтэй уялдуулан мөн заалтын “судалгаа хийж” гэснийг “судалгаа хийх” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 54.5 хувиар дэмжигдлээ.

3.Төслийн 49 дүгээр зүйлийн 49.4.11 дэх заалтын дугаарыг “49.4.12” гэж өөрчлөн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“49.4.12.энэ хуульд заасан баталгааг цахим системээр гаргах эрх бүхий этгээдтэй гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүд анхааралтай

хандаарай. Санал хураалт. 54.5 хувиар дэмжигдлээ.

4.Төслийн 49 дүгээр зүйлийн 49.5 дахь хэсгийн “өөрийн гүйцэтгэх ажлын тодорхой хэсгийг” гэснийг “энэ хуулийн 49.4.5, 49.4.8, 49.4.10-т заасан чиг үүргийг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 54.5 хувиар дэмжигдлээ.

5.Төслийн 49 дүгээр зүйлийн 49.8.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“49.8.3.худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас өгсөн чиглэлийн дагуу энэ хуулийн 49.4.10-т заасан судалгаа хийх;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 54.5 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 50 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 50 дугаар зүйл дээр ажлын хэсгийн 2 санал байгаа. Саналыг уншиж танилцуулъя.

1.Төслийн 50 дугаар зүйлийн 50.4 дэх хэсгийн “, хөндлөнгийн” гэснийг хасаж, мөн зүйлийн 50.5, 50.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, үүнтэй уялдуулан 50.7, 50.8 дахь хэсгийг хасах:

“50.5.Үнэлгээний хорооны хараат бус гишүүнээр иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллагын төлөөллийг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотоос бусад орон нутагт аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг сонгоно.

50.6.Үнэлгээний хороонд тухайн бараа, ажил, үйлчилгээнд холбогдох салбарт мэргэшсэн хүнийг томилон ажиллуулж болно.” Санал гаргасан

ажлын хэсэг. Санал хураалт. 54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 50 дугаар зүйлийн 50.15 дахь хэсгийн “урамишуулал олгох, мэргэшсэн ажилтан бэлтгэх” гэснийг “үнэлгээний хорооны гишүүнд урамишуулал олгохтой холбогдсон” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүд анхааралтай хандаарай. 45.5 хувиар санал дэмжигдсэнгүй. Раднаасэд, Пүрэвдорж гишүүн. Пүрэвдорж гишүүн санал гаргая.

Б.Пүрэвдорж: Миний энэ микрофон улайгаад ажилласангүй.

Г.Тэмүүлэн: Пүрэвдорж гишүүний саналаар сая хураасан санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. Санал хураалт. 54.5 хувиар дэмжигдлээ. Гэхдээ Пүрэвдорж гишүүнийх эсрэг гарч байна.

Саяны Төслийн 50 дугаар зүйлийн 50.15 дахь хэсгийн “урамишуулал олгох, мэргэшсэн ажилтан бэлтгэх” гэснийг “үнэлгээний хорооны гишүүнд урамишуулал олгохтой холбогдсон” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Гишүүд анхааралтай хандаарай. Санал хураалт. 63.6 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 51 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.Танилцлаа.

Хуулийн төслийн 52 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Танилцлаа.

Хуулийн төслийн 53 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Танилцлаа.

Хуулийн төслийн 54 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Танилцлаа.

Хуулийн төслийн 55 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Танилцлаа.

Хуулийн төслийн 56 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 56 дугаар зүйл дээр ажлын хэсгийн 1 санал байгаа. Уншиж танилцуулъя. 56 дугаар зүйлтэй холбогдуулж, Төслийн 56 дугаар зүйлийн 56.10 дахь хэсгийн “байцаагчид гаргана” гэснийг “байцаагчид гаргаж болно” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 54.5 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 57 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 57 дугаар зүйл дээр ажлын хэсгийн 1 санал байгаа. Уншиж танилцуулъя.

Төслийн 57 дугаар зүйлийн 57.4 дэх хэсгийн “гэрээ байгуулах эрх олгохгүй” гэснийг “энэ хуулийн 28.1-д заасан шийдвэр гаргахгүй” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63.6 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 58 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Танилцлаа.

Хуулийн төслийн 59 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Танилцлаа.

Хуулийн төслийн 60 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Танилцлаа.

Хуулийн төслийн 61 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Танилцлаа.

Хуулийн төслийн 62 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 62 дугаар зүйл дээр ажлын

хэсгийн 1 санал байгаа. Санал хураалтын өмнө саналыг танилцуулъя.

Төслийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсгийн “2023 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс” гэснийг “2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Тогтохсүрэн, Раднаасэд гишүүд. Раднаасэд гишүүн санал гаргая.

Ш.Раднаасэд: Би сая анхааралгүй байж байгаад санал өгсөнгүй. Дахин санал хураалгаж өгөөч.

Г.Тэмүүлэн: Раднаасэд гишүүний саналаар саяны санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай. Дахиад Пүрэвдорж гишүүн. Пүрэвдорж гишүүн санал гаргая.

Б.Пүрэвдорж: Миний хуруу тос болоод ерөөсөө болохгүй байна. Санал хурааж өгнө уу.

Г.Тэмүүлэн: Пүрэвдорж гишүүний саналаар санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. Санал хураалт. 63.5 хувиар дэмжигдлээ. Пүрэвдорж гишүүний санал дэмжигдсэн тул 62 дугаар зүйлийг дахиж санал хураая.

Төслийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсгийн “2023 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс” гэснийг “2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт. 54.5 хувиар дэмжигдлээ.

Дээрх дугаар, зүйл, заалтууд дэмжигдсэн тул нийт төслийн хүрээнд,

Төсөлд зүйл, хэсэг, заалт хасах, нэмэх саналтай уялдуулан төслийн холбогдох зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг

нийцүүлэн өөрчлөх, мөн төслийн үг хэллэг, нэр томъёог жигдлэх засварыг хийх . Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

54.5 хувиар дэмжигдлээ.

Найруулгын санал

1.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “өргөтгөх,” гэсний дараа “буулгах,” гэж, 56 дугаар зүйлийн 56.5.3 дахь заалтын “хохирол” гэсний дараа “барагдуулахыг” гэж, 56.11 дэх хэсгийн “байцаагч” гэсний дараа “энэ хуулийн 56.10-т заасан” гэж тус тус нэмэх;

2.Төслийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “хөгжлийн болон хүнд, хөнгөн” гэснийг “хөгжлийн, хүнд болон хөнгөн” гэж, мөн зүйлийн 8.4.3, 8.7.1 дэх заалтын “хотод хамаарахгүй” гэснийг “хотоос бусад харьяалалтай” гэж, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “аргад үндэслэн” гэснийг “аргаар” гэж, 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийн “нууцалж, бусад хэсгийг ил болгохоор” гэснийг “энэ хуулийн 29.2-т зааснаар ил болгохгүйгээр” гэж, 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсгийн “Засгийн газрын баталсан жагсаалтад” гэснийг “энэ хуулийн 45.2-т заасан жагсаалтад” гэж, 49 дүгээр зүйлийн 49.4.9 дэх заалтын “дүгнэлт” гэснийг “дүн шинжилгээ” гэж, 49.8.1 дэх заалтын “хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж,” гэснийг “хууль тогтоомжийн хэрэгжилтийн” гэж, 56 дугаар зүйлийн 56.7 дахь хэсгийн “зааснаар улсын байцаагчийн гаргасан санал, дүгнэлтийг” гэснийг “заасан дүгнэлт, зөвлөмжийг” гэж, мөн хэсгийн “биелэлтийн талаар” гэснийг “дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар” гэж, 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсгийн “сонирхолтой” гэснийг “хохиролтой” гэж, төслийн 9, 37, 45, 49, 53, 54, 58 дугаар зүйлийн гарчиг болон холбогдох хэсэг, заалтад тусгагдсан худалдан авах ажиллагааны болон өрсөлдөөний асуудал “эрхэлсэн” гэснийг тохиолдол бүрд “хариуцсан” гэж, төсөлд тусгагдсан “энэ зүйлийн”

гэснийг тохиолдол бүрд “энэ хуулийн” гэж тус тус өөрчлөх;

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “уг ажиллагаанд” гэснийг, 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалтын “эрх бүхий” гэснийг, 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын эшлэлийг, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “тохиолдолд” гэснийг, 22 дугаар зүйлийн 22.10 дахь хэсгийн “санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тогтоосон” гэснийг, 48 дугаар зүйлийн 48.2.13 дахь заалтын “эрх, үүрэг” гэснийг, 49 дүгээр зүйлийн 49.4.14 дэх заалтын “чиг үүрэг” гэснийг, 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсгийн “болон бусад” гэснийг, 53 дугаар зүйлийн 53.2 дахь хэсгийн “зохих” гэснийг, 55 дугаар зүйлийн 55.1.7 дахь заалтын “тоо баримт,” гэснийг, 56 дугаар зүйлийн 56.8, 56.12 дахь хэсгийн “худалдан авах ажиллагааны” гэснийг болон 56.8 дахь хэсгийн “тушаал гаргаж,” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 54.5 хувиар дэмжигдлээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийн явуулъя.

Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн талаар санал хураалт явуулъя. Санал байна уу. Алга байна. Танилцлаа. Зарчмын зөрүүтэй санал байхгүй тул танилцлаа.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Танилцлаа.

Хуулийн төслийн 2 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Танилцлаа.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ

худалдан авах тухай шинэчилсэн найруулгын хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар асуулт асууж санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр ажлын хэсгийн 1 санал байгаа. Саналыг уншиж танилцуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн “мөрдөгдөхөөс” гэснийг “болохоос” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63.6 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр ажлын хэсгийн 1 санал байгаа.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “бүртгэлд бүртгэгдсэн этгээд бүртгэлийн үлдсэн хугацаагаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэлтэй” гэснийг “бүртгэл хүчинтэй хэвээр” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүд анхааралтай. 63.6 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Танилцлаа.

Зөвлөлдөх санал асуулгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар асуулт асууж, санал гаргах гишүүн байна уу.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр ажлын

хэсгийн 1 санал байгаа. Саналыг уншиж танилцуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн “34 дүгээр” гэснийг “33 дугаар” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63.6 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Танилцлаа.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Танилцлаа.

Улсын нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн нэрийг өөрчлөхөөр ажлын хэсгээс санал ирүүлсэн тул уг саналтай холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн нэрийг өөрчлөх ажлын хэсгийн 1 саналыг хураана. Саналыг уншиж танилцуулъя.

Хуулийн төслийн нэрийн “хуульд өөрчлөлт оруулах” гэснийг “хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. 54.5 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Танилцлаа.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Танилцлаа.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар асуулт асууж, санал хэлэх гишүүд байна уу. Алга байна. Танилцлаа. Хуулийн төслийн нэрийг өөрчлөхөөр ажлын хэсгээс санал ирүүлсэн тул уг саналтай

холбогдуулж асуулт асууж санал хэлэх гишүүд байна уу. Хуулийн төслийн нэрийг өөрчлөх ажлын хэсгийн 1 санал байгаа. Саналыг уншиж танилцуулъя.

Хуулийн төслийн нэрийн “хуульд өөрчлөлт оруулах” гэснийг “хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63.6 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Танилцлаа.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Танилцлаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар асуулт асууж, санал хэлэх гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн нэрийг өөрчлөхөөр ажлын хэсгээс санал ирүүлсэн тул уг саналтай холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн нэрийг өөрчлөх ажлын хэсгийн 1 санал байгаа. Саналыг уншиж танилцуулъя.

Хуулийн төслийн нэрийн “хуульд өөрчлөлт оруулах” гэснийг “хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай. 63.6 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Танилцлаа.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Танилцлаа.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт

оруулах тухай хуулийн төслийн талаар асуулт асууж, санал хэлэх гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн нэрийг өөрчлөхөөр ажлын хэсгээс санал ирүүлсэн тул уг саналтай холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн нэрийг өөрчлөх ажлын хэсгийн 1 санал байгаа. Саналыг уншиж танилцуулъя.

Хуулийн төслийн нэрийн “хуульд өөрчлөлт оруулах” гэснийг “хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Анхааралтай байгаарай. Санал хураалт. 54.5 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Танилцлаа.

Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье. Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулж асуулт асууж, санал хэлэх гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн нэрийг өөрчлөхөөр ажлын хэсгээс санал ирүүлсэн тул уг саналтай холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн нэрийг өөрчлөх ажлын хэсгийн 1 санал байгаа. Саналыг уншиж танилцуулъя.

Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хуулийн төслийн нэрийн “хуульд өөрчлөлт оруулах” гэснийг “хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63.6 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Танилцлаа.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал хураалт явуулж эхэлье. Уг хуулийн төсөлтэй холбогдуулж асуулт асууж, санал хэлэх гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд ажлын хэсгийн 1 санал байгаа. Уншиж танилцуулъя.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах төслийн талаар 1 дүгээр зүйлтэй холбогдуулж

Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 112 дугаар зүйлийн 112.10 дахь хэсгийн “цахимаар татан авч” гэснийг “цахимаар авч” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж ажлын хэсгийн 1 санал байгаа. Саналыг уншиж танилцуулъя. 3 дугаар зүйлтэй холбогдуулж,

Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн дугаарыг “4” гэж өөрчлөн, төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмж,

үүнтэй уялдуулан төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын “62.1.5 дахь” гэснийг “62.1.4 дэх” гэж, төслийн нэрийн “нэмэлт” гэснийг “нэмэлт, өөрчлөлт” гэж тус тус өөрчлөх:

“3 дугаар зүйл.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.4 дэх заалтын дугаарыг “62.1.5” гэж өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63.6 хувиар дэмжигдлээ.

Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар асуулт асууж, санал хэлэх гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж ажлын хэсгийн 1 санал байгаа. Саналыг уншиж танилцуулъя.

Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар, төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж,

Төслийн 1 дүгээр зүйлийн “хэсгийн” гэсний дараа ““Шинжээчийг сонгохдоо” гэснийг “Шинжээчийн” гэж,” гэж, “өөрчилсүгэй” гэсний өмнө “тус тус” гэж, “тусгаж,” гэсний дараа “түүнийг” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63.6 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. 2 дугаар зүйлтэй холбогдуулж ажлын хэсгийн 1 санал байгаа.

Төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63.6 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгийн 1 саналтай байгаа.

Төслийн 3 дугаар зүйлийн дугаарыг “2” гэж өөрчлөх . Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63.6 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Төслийн 4 дүгээр зүйлийн дугаарыг “3” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. 63.6 хувиар дэмжигдлээ.

Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал хураалт явуулж эхэлье. Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулж асуулт асууж, санал хэлэх гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд ажлын хэсгийн 1 санал байгаа. Саналыг уншиж танилцуулъя.

Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар 1 дүгээр зүйлтэй холбогдуулж, Төслийн 1 дүгээр зүйлийг болон төслийн нэрийн “нэмэлт,” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63.6 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр ажлын хэсгийн 1 санал байгаа. 2 дугаар саналыг уншиж танилцуулъя.

Төслийн 2 дугаар зүйлийн дугаарыг “1” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын

хэсэг. Санал хураалт. 54.5 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна. 3 дугаар зүйлтэй холбогдуулж ажлын хэсгийн 1 санал байгаа.

Төслийн 3 дугаар зүйлийн дугаарыг “2” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63.6 хувиар дэмжигдлээ.

Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал хураалт явуулж эхэлье.

Барилгын тухай хуультай холбогдуулж асуулт асууж, санал хэлэх гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Танилцлаа.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Танилцлаа.

Олон нийтийн радио телевизийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал хураалт явуулж эхэлье. Хуулийн төсөлтэй холбогдуулж асуулт асууж, санал хэлэх гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төсийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Танилцлаа.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Танилцлаа.

Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал хураалт явуулж эхэлье. Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулж асуулт асууж, санал хэлэх гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 1 дүгээр

зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд ажлын хэсгийн 1 санал байгаа. Саналыг уншиж танилцуулъя.

Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар, 1 дүгээр зүйлтэй холбогдуулж, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Даатгалын тухай хуулийн 6¹ дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 6^{1.4} дэх хэсэг нэмсүгэй:

“6^{1.4}. Даатгагч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гаргах баталгааны үнийн дүн даатгалын нөөц сангийн энэ хуулийн 6^{1.1}-д заасан баталгаанд хамаарах эрсдэлийн сангаас хэтэрсэн бол давхар даатгалд хамрагдаж, эрсдэлийн үнэлгээ хийсэн байхыг шаардана.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Гишүүд анхааралтай хандаарай. 54.5 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Танилцлаа.

1 санал байгаа. 1 зүйл үлдсэн. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл дээр 5 дугаар зүйл дээр Раднаасэд гишүүн зарчмын зөрүүтэй санал гаргасан байна. Саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

Зарчмын зөрүүтэй саналын томъёолол. 5 дугаар зүйл.

5.2 дах хэсэг нэмэх. Эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авахад энэ зүйлийн хэмнэлтэй байх буюу бага үнийг сонгох аргыг хэрэглэхгүй. Санал гаргасан Улсын Их

Хурлын гишүүн Раднаасэд. Раднаасэд гишүүн тайлбар хэлье.

Ш.Раднаасэд: Ийм байдлаар л тодорхойлж байна л даа. Энэ Худалдан авах ажиллагааны юм болохоор нөгөө 80 хувиас нийт тендер зарлагдсан үнийн 80-аас доош хувийн үнэ хэлэх юм бол хүчингүй болно гэдэг ч юм уу ингээд зөвхөн үйлдвэрлэж байгаа эм дээрээ тооцоод байна л даа. Бид нар импортоор маш их хэмжээний эм авч байгаа.

Хоёрдугаарт нөгөө тендерийн үнэлгэ дээр чинь нэг зүйл байгаа шүү дээ. Нэг үйлдвэрлэгчээс захиалгаар авах. Тэр дээр онцгой эм гээд ямар байх нь мэдэгдэхгүй. Зарим төрлийн онцгой эм гээд бүх эм, эмнэлгийн хэрэгсэл чинь ерөөсөө багтахгүй байгаа байхгүй юу. Онцгой эм гэдэгт юуг ч хамааруулах гээд байгаа юм. Хэн нь тэр онцгой гэдгийг үзэх нь ч ойлгомжгүй. Тийм учраас энэ зарчим дээр нь би хэмнэлттэй байх гэдэг агуулга дотор нь тэр бага үнийн аргаар сонгох сонголтыг хийхгүй шүү эм, эмнэлгийн хэрэгсэл дээр гэдгийг тодорхойлж өгөөд байгаа юм. Бага үнийн арга гэдэг зарчим бол энэ дотор байхгүй байгаа ч гэсэн хэмнэлттэй байна гэдэг нь өөрөө нэгдүгээрт үнийн асуудал, хоёрдугаарт бүх зүйл ороод байгаа юм. Цаг хугацаа, өртөг, бүх зүйл дээрээ ороод байх шиг байгаа юм. Үйлчилгээ дээрээ очихоор бас арай өөр, бараа бүтээгдэхүүн дээр бас арай өөр. Тийм учраас энэ дээр би хэмнэлттэй байх буюу бага үнийн аргыг сонгохгүй гэсэн агуулгаар бичиж байгаа шүү.

Г.Тэмүүлэн: Раднаасэд гишүүний саналаар санал хураалтыг явуулъя. Сана хураалт. Дэмжье гэдгээр санал хураана. 45.5 хувиар дэмжигдсэнгүй.

Ингээд хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн

Сандаг-Очир нэгдсэн хуралдаанд танилцуулна.

Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Сая Раднаасэд гишүүний саналыг хэлэлцсэн. Чуулганаар орж байгаад бид хэд тодорхой тайлбар өгөөд, дахиж угаасаа санал хураагдана. Тэгэхээр хөндөгдсөн заалт учраас эцсийн хэлэлцүүлэг дээр бид нар хөндөж өөрчилж болно. Ажлын хэсэг энэ дээр анхаарах хэрэгтэй байна. Ажлын хэсэгт баярлалаа.

11.09 цаг.

Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын сүүлийн 15 жилийн төсвийн бодлого, төсвийн тэнцэлд дүн шинжилгээ хийх, цаашид баримтлах төсвийн бодлогын талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн дүгнэлттэй танилцах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай/

Байнгын хорооны 2020 оны 05 дугаар тогтоолоор Монгол Улсын сүүлийн 15 жилийн төсвийн бодлого, төсвийн тэнцэлд дүн шинжилгээ хийх, цаашид баримтлах төсвийн бодлогын талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Булгантуяагаар ахлуулж ажиллуулсан. Уг ажлын хэсгийн санал, дүгнэлтэд тусгасан цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үр дүнд Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай Байнгын хорооны тогтоолын төслийг бэлтгэн Төсвийн байнгын хороонд ирүүлсэн байна.

Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Байгалмаагийн Одонтуяа Сангийн

яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Батхишигийн Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төлбөрийн тэнцлийн хэлтсийн дарга, Намхайжанцаны Энхцацрал Эдийн засаг, хөгжлийн яамны Худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын ахлах мэргэжилтэн.

Ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч Булгантуяа сайд хийнэ. Булгантуяа сайдад микрофон өгье.

Х.Булгантуяа: Төсвийн байнгын хорооны 2020 оны 11 дүгээр сарын 04-ны өдрийн 05 дугаар тогтоолоор Монгол Улсын сүүлийн 15 жилийн төсвийн бодлого, төсвийн тэнцэлд дүн шинжилгээ хийж, цаашид баримтлах төсвийн бодлогын талаар санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Г.Амартүвшин, Х.Баделхан, Ж.Батсуурь, Г.Тэмүүлэн, Б.Чойжилсүрэн нар ажиллаа.

Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнд Төсвийн байнгын хорооны ажлын алба, Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтэс, Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Үндэсний аудитын газрын холбогдох албан тушаалтнуудыг оролцуулан ажиллууллаа.

Ажлын хэсэг 5 удаа, ажлын дэд хэсэг 3 удаа хуралдаж, ажлын хэсгээс өгсөн үүрэг чиглэлийн дагуу ажлын дэд хэсгээс 2005-2021 оны төсвийн мэдээллийг нэгтгэж, дүн шинжилгээ хийж сүүлийн 15 жилийн төсвийн төлөвлөлт, төсвийн гүйцэтгэл болон хууль, тогтоомжид нийцэж байгаа эсэх талаарх дүгнэлт гарган ажлын хэсгийн хуралдаанд танилцуулсан.

Мөн Дэлхийн банкны холбогдох мэргэжилтнүүд 2019 онд тус байгууллагаас эмхэтгэн гаргасан Монгол Улсын сүүлийн 10 жилийн төсвийн зардлын тойм судалгааг танилцуулсан.

Монгол Улсын сүүлийн 15 жилийн төсвийн баримталсан бодлого, төсвийн тэнцэлтэй холбоотойгоор ажлын хэсгийн албан хэрэгцээнд цуглуулсан баримт, тоо мэдээлэл болон холбогдох байгууллагаас гаргасан дүгнэлт судалгаа, зөвлөмжүүдийг судлан үзээд ажлын хэсгээс Монгол Улсын сүүлийн 15 жилийн төсвийн бодлого, төсвийн тэнцлийг дүгнэж санал дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. Уг хуралдаанаар Байнгын хорооны дарга, гишүүдийн өгсөн чиглэлийн дагуу Засгийн газарт чиглэл өгөх тухай Байнгын хорооны тогтоолын төслийг боловсруулан та бүхэн танилцуулж байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгийн ахлагч Булгантуяа сайдад баярлалаа.

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулж үг хэлэх гишүүд байна уу. Батжаргал гишүүнээр тасалъя.

Ж.Батжаргал: Сүүлийн 15 жилийн төсвийн байдалд дүн шинжилгээ хийгээд зайлигүй авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийнхээ талаар тогтоолын төсөл боловсруулж орж ирсэн байгаа юм. Тэгээд ер нь бол дэмжиж байгаа юм. Энэ 4 дэх заалт буюу тэр төрийн өмчтэй болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийнхээ чиглэлээр оруулж ирж байгаа заалт өөрөө их тийм жул заалт болчихоод байгаа юм. Ер нь яг нарийндаа Төрийн өмчтэй компаниудын олон нийтийн болгох, хариуцлага сахилгыг дээшлүүлэх, янз бүрийн нүүрлэсэн бусармаг

үйлдлүүдийг ул сууриар нь устгах эрх зүйн орчныг нь бүрдүүлэх чиглэлээр бид олон удаа ярьсан. Тэгэхээр энэ тогтоол дотор төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, төрийн болон орон нутгийн өмчит компаниудын тухай хууль, тэр хууль дотор ТУЗ, Гүйцэтгэх захирлын эрх, үүргийн хязгаар юмнуудыг тодорхой болгох, ил тод, нээлттэй байдлыг нь хангах чиглэлээр ер нь ямархуу байдлаар хэдүүлээ энэ тогтоолоор чиглэл өгч байж нэлээн бил нарын яриад байгаа асуудал зөв зохистой болох цаг хугацаа наашаа татагдаж орж ирэх байлаа. Энэ дээр тодорхой бодож, асуудалд хандан ёстой болов уу гэсэн ийм бодолтой байна.

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүний саналыг сонслоо. Тэгэхээр эн тогтоолын төсөл дээр Батжаргал гишүүний саналыг тусгаад, тэр дундаа 4 дүгээр зүйл буюу төрийн өмчийн болон өмчийн оролцоотой аж ахуйн нэгжсийн чиглэлээр тодорхой илүү дэлгэрэнгүй, тодорхой нарийвчилсан заалтуудыг тусгах шаардлагатай байна. Тэгэхээр ажлын хэсэг дээрээ энэ асуудлыг редакцын засвар дээрээ тусгаад батлаад явъя гэсэн ийм саналтай байна.

Булгантуяа сайд санал хэлэх үү.

Х.Булгантуяа: Батжаргал гишүүний хэлж байгаа санал үнэн. Энэ төрийн өмчийн ер нь төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийг тайлан мэдээллийг Улсын Их Хурал дээр бараг л сонсдог байх ёстой юм байна лээ. Тэгэхгүй бол бид нар төсөв дээр гэхэд төсвийн орлогын 70, 80 хувийг татвар бүрдүүлдэг. Түүний 70, 80 хувийг топ-100 компанийн бүрдүүлдэг. Тэгээд татвараас бусад ногдол ашгаар орж ирж байгаа орлого бол маш бага. Ер нь бол бараг байхгүй. Эсрэгээрээ төрийн өмчит компаниудын өр зээлийн хэмжээ маш өндөр. Дамжуулан зээллэг энэ тэр бол маш өндөр байсан. Энэ 15 жилийн дүн шинжилгээнээс. Ямар ч асуудалгүй авчихдаг. Төрийн өмчит битгий хэл орон

нутгийн өмчит нь ч мөн адилхан авчхаад тэгээд буцаагаад төлөх болохоор төлдөггүй. Тэгээд бид нар төсвөөсөө өөрөөр хэлбэл татвар төлөгчдийн мөнгөөр төлж байдаг ер нь ийм болчихсон юм байна лээ. Тэгээд энэ тайлан мэдээллүүд нь тийм амархан олдохгүй. Сая Эдийн засгийн байнгын хороо дээр мэдээлэл авах гэхээр энэ ч ер нь бараг та нарт танилцуулдаг асуудал биш дээ гээд. Өөрөөр хэлбэл бид нар ч энэ мэдээллийг олж авч чадахгүй байгаа юм чинь жирийн иргэд бол олж аваад, ийм байна гэдэг хэцүү юм байна лээ. Одоо харин Учрал сайд шилэн ажиллагааны үр дүнд нэлээдгүй ТУЗ-ийн гишүүд, үйл ажиллагаа, түрээс, орлого гээд хамаг юмыг нь ил болгож байх шиг байна. Тэгээд энэ дээр бүр нэлээн олон зүйл, заалттай чиглэл өгч болно. Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороо мэдээллүүдийг нь авч сонсдог. Дээр нь нэмээд Засгийн газраас бас төрийн өмчийн компаниудын тухай авах арга хэмжээнүүдийг нэлээдгүй оруулж байгаа. Нэлээн том бодлогын баримт бичиг оруулъя гэж байгаа юм байна. Засаглалыг сайжруулах, зармыг нь олон нийтийн хяналтад оруулах, ил тод болгох гээд. Тэгэхээр тэр чиглэлээр редакц хийгээд батлуулъя.

Г.Тэмүүлэн: Булгантуяа гишүүнд баярлалаа. Тэгэхээр Батжаргал болон Булгантуяа гишүүдийн хэлсэн саналыг тогтоолын төсөлд нэмж тусгаад эцэслэн баталъя гэсэн саналтай байна. Зөв зүйтэй саналуудыг дэвшүүлж байна.

Ингээд Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулж гишүүд үг хэлж дууслаа.

“Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт. 63.6 хувиар дэмжигдлээ. Ингээд Байнгын хорооны тогтоолыг хэлэлцэж, шийдвэрлэлээ.

Өнгөрсөн хугацаанд ажилласан Булгантуяа ахлагчтай ажлын хэсгийн гишүүдэд талархал дэвшүүлбэ.

Монгол Улсын сүүлийн 15 жилийн төсвийн бодлого, төсвийн тэнцэлд дүн шинжилгээ хийх, цаашид баримтлах төсвийн бодлогын тодорхой үр дүнтэй шийдэл гаргасан шийдлүүдийг гаргаж, Байнгын хорооны тогтоол болгон оруулж ирж, батлууллаа. Цаашид төсвийн шинэчлэлийг эрчимжүүлэх, өрийн удирдлага, төсвийн төлөвлөлт, төсвийн үр ашиг, санхүүгийн төрийн удирдлагыг сайжруулах чиглэлээр тодорхой Засгийн газар болон Сангийн яам анхаарч ажиллахыг, тогтоолын хэрэгжилтийг мөрдөж ажиллахыг тодотгож хэлье.

Ингээд өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Идэвхтэй оролцсон гишүүдэд баярлалаа.

11.17 цаг.

Дууны бичлэгээс буулгасан:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ